

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2008 оны 3-р сарын 27-ны өдрийн  
ХШ хуралдааны 02 дугаар  
тогтоолын хавсралт.

# **ТӨВ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР**

**(2008 – 2023 он)**

**Зуунмод сум  
2008 он.**

## ГАРЧИГ

<b>АЙМГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....</b>	<b>3</b>
<b>АЙМГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ. ҮЕ ШАТ.....</b>	<b>5</b>
<b>НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ.....</b>	<b>6</b>
1.1. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, салбарын зохистой бүтцийг бий болгох талаар.....	6
1.2. Үйлдвэр, үйлчилгээний салбарын хөгжил.....	8
1.3. Хөдөө аж ахуйн хөгжил.....	11
1.4. Дэд бүтцийн хөгжил.....	14
1.4.1. Зам тээврийн хөгжил.....	14
1.4.2. Эрчим хүчний салбарын хөгжил.....	17
1.4.3 Мэдээлэл, харилцаа холбооны хөгжил.....	19
1.5. Аялал, жуучлалын салбарын хөгжил.....	20
1.6. Барилга, хот байгуулалтын хөгжил.....	21
<b>ХОЁР. НИЙГМИЙН ХӨГЖИЛ.....</b>	<b>24</b>
2.1. Хүн амын өсөлт, хүний хөгжлийг хангах талаар.....	24
2.2. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах талаар.....	24
2.3. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар.....	26
2.4. Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар.....	28
2.5. Хүн амын боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх талаар.....	30
<b>ГУРАВ. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ</b>	<b>34</b>
3.1. Агаар мандлын хамгаалал.....	34
3.2. Газрын нөөцийн ашиглалт, хамгаалал.....	36
3.3. Усны нөөцийн ашиглалт, хамгаалал.....	37
3.4. Ойн нөөцийн ашиглалт, хамгаалал.....	39
3.5. Цөлжилт, гантай хийх тэмцэл.....	41
3.6. Биологийн төрөл зүйлийн хамгаалал.....	42
3.7. Байгалийн гамшгаас сэргийлэх, хохирлыг бууруулах талаар.....	43
<b>ДӨРӨВ. НУТГИЙН УДИРДЛАГА, ЭРХ ЗҮЙН ТАЛААР.....</b>	<b>45</b>
4.1. Нутгийн удирдлагын талаар.....	45
4.2. Хууль эрх зүйн талаар.....	46
4.3. Батлан хамгаалах, онцгой байдлын хөгжлийн талаар.....	48
<b>ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТЛЭГ АРГА ХЭРЭГСЭЛ.....</b>	<b>50</b>
5.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үндсэн чиглэл.....	50
5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр.....	50
5.3. Олон нийтийн оролцоо.....	51
<b>ЗУРГАА. Аймгийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үзүүлэлтүүд.....</b>	<b>52</b>

### **ХАВСРАЛТ 1. ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛАХАД АШИГЛАСАН СУДАЛГААНУУД**

## АЙМГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Бүсийн тулгуур төв хотыг тогтоох тухай УИХ-ын 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 01 дүгээр тогтоол, Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Аймгийн боловсролыг 2007-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, Нийгмийн эрүүл мэндийн талаар аймгаас баримтлах бодлого болон зах зээлийн тогтолцоонд шилжиж эхэлсэн үеэс эдүгээ хүртэл хэрэгжүүлж ирсэн хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүдийн үзэл санаа, хэрэгжилтийн явц, үр дүн, залгамж чанар нь аймгийн хөгжлийн энэхүү хөтөлбөрт тусгалаа олж уг хөтөлбөрийг боловсруулах үзэл баримтлалын үндэс болсон юм.

Манай аймагт 2007 оны байдлаар 88828 хүн оршин сууж байна.

Аймагт 1 км<sup>2</sup> нутагт 0,8 хүн ногдож байгаа нь улсын дундаж (1.5)-аас 0,7 пунктээр бага байгаа хэдий ч хүн амын нягтрал харьцангуй ихтэй аймгуудын тоонд орж байна. Хүн амын жилийн дундаж өсөлт 1963-1969 онд 3.2% байснаа 1989-2000 онд эрс буурч -0.1% болсон нь 1990-ээд оноос хойш хүн амын төрөлт буурч, шилжих хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой тул аймагт 1990 онд 1000 хүнд ногдох төрөлт 35.84, нас баралт 6,96, цэвэр өсөлт 28.88 байснаа 2007 онд төрөлт 8,61, нас баралт 4,37, цэвэр өсөлт 4,24 болж буурчээ. Сүүлийн нэг жилд аймагт 1,5 мянган хүн шилжин ирж, 3,2 мянган хүн шилжин явсан байна.

Аймгийн нийт хүн амын 63.69 хувь нь буюу 56347 нь хөдөлмөрийн насны хүн ам байна. Үүний 43648 (77.46 %) ажиллагсад байна.

2000 оноос Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн тоо 1.5 хувиар буурч, аймгийн ажилгүйдлийн түвшин улсын дунджаас доогуур 1,6 - 1,7 хувьтай байна.

Аймгийн нийт өрхийн 27,1 хувийг /ядуу өрх- 17,4%, нэн ядуу өрх 9.7/ ядуу, нэн ядуу өрх эзлэж байна.

Аймагт боловсрол, эрүүл мэндийн салбарын хүрээний тулгамдсан асуудлууд ч цөөнгүй байна.

Цаашид аймгийн хөгжлийн давуу тал, нөөц боломжийг бүрэн ашиглаж, үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин ажлын байрыг олноор бий болгох, эдийн засгийн өсөлт, тэргүүлэх салбаруудын хөгжил, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж ядуурлыг эрс бууруулах шаардлагатай.

Аймагт 2006 оны байдлаар улсын нийт ДНБ-ний 2,4 хувь, бүсийн нийт ДНБ-ий 24,0 хувь нь тус тус ногдож байна. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ тус аймагт 851,9 мян.төгрөг байгаа нь бүсийн дундаж (721,5 мян.төг)-аас 1,2 хувиар илүү, улсын дундаж (1222)-аас 45,6 хувиар тус тус бага байна. Бүсийн хэмжээнд тус аймаг энэ үзүүлэлтээр өмнөх онуудаас өссөн байна.

2007 оны байдлаар аймгийн ДНБ-д хөдөө аж ахуйн салбар 74.5 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 3,5 хувь, үйлчилгээний салбар 22.0 хувийг тус тус эзэлж байна.Өнөөгийн байдлаар манай аймагт аж үйлдвэр сул хөгжсөн, эдийн засгийн бүтэц оновчтой бусаас хөгжлийн хурдац удаашралтай байна.

Цаашид бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх хийгээд эдийн засгийн өсөлтийг хурдасгах, эдийн засгийн салбарын бүтцийг боловсронгуй болгох асуудал анхаарал татаж байна.

Аймгийн эдийн засагт мал аж ахуй, газар тариалан голлодог.

Аймаг 2007 оны эцэст 2626.5 мянган толгой малтай болсон ба нийт сүрэгт тэмээ 0.1, адуу 8.2, үхэр 6.0, хонь 47.6, ямаа 38.1 хувийг эзэлж байна.

Сүүлийн жилүүдэд малын тоо толгой нийт дүнгээрээ өсч байгаа хэдий ч тэмээн сүрэг жил дараалан буурч, ямаан сүргийн өсөлт хурдацтай явагдаж улмаар сүрэгт эзлэх хувийн жин өндөрсөж, сүргийн бүтцэд муугаар нөлөөлөх болов.

Газар тариалан 1990 он хүртэл аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг байсан хэдий ч сүүлийн жилүүдэд энэ салбарын үйлдвэрлэл нэлээд буурсан.

2007 оны байдлаар тариалангийн талбайн 247561 га газар байгаа бөгөөд энэхүү талбайн 46.9 хувийг буюу 116207.7 га талбайг эзэмшиж байна. Нийт эзэмшсэн талбайн 32% -д нь буюу 36934 га талбайд тариалалт явуулж 25.6 мянган га-д уринш боловсруулсан нь эзэмшиж байгаа талбайн дөнгөж 54 хувийг ашиглаж 54 мян. га газрыг эзэмшихгүй өнжөөж байна.

Төрөл бүрийн замын сүлжээний хангамжийн үнэлгээгээр аймаг (1.46) бүсийн хэмжээнд Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн дараа орох ба улсын хэмжээнд харьцангуй сайн замын сүлжээтэй аймгуудын тоонд орж байна. Энэ нь манай улсын төмөр замын болон сайн чанарын авто замын гол тэнхлэг аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөгтэй холбоотой юм.

Манай аймгийн бүх сумд Улаанбаатар, Дархан, Хархорин, Багануураас эрчим хүчээр хангагдаж, эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон.

Холбооны үйлчилгээнд өндөр хурдны сүлжээ тоон системийг бүрэн нэвтрүүлэх, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулах, мэдээллийн технологийг айл өрхөд хүргэх, холбоо мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, хиймэл дагуулын болон бага багтаамжийн радио релейн шугам, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулах шаардлагатай.

Аймаг нь Төвийн бүсийн хэмжээнд төдийгүй улсын хэмжээнд ашигт малтмалын нөөцөөр тэргүүлэх байр суурьтай бөгөөд тэр дундаа алт, нүүрсний нөөцөөр баялаг.

Зуунмод сум нь Монгол орны аялал жуулчлалын тэргүүлэх онцгой бүс болох Улаанбаатарын бүс буюу нийслэлээс 45 км зайтай байрладаг, дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн, байгаль, түүх, соёлын аялал жуулчлал хөгжүүлэх нөөц, боломж ихтэй.

Байгалийн нөөцийн ашиглалт, хамгааллын холбогдолтой шийдвэрлэвэл зохих асуудлууд ч цөөнгүй байна. Сүүлийн жилүүдэд малын тоо толгой өсөж, нийт нутгийн хэмжээгээр бэлчээрийн даац хүрэлцэхгүй байдал ажиглагдаж байна. Худаг, ус тойрсон бага хэмжээний газар олон тооны мал төвлөрч бэлчээрийн талхагдлыг ихэсгэж байна. Ойг зөвшөөрөлгүйгээр огтолж ашиглах явдал байсаар байгаа. Цөлжилтөөс хамгаалах явдал нь байгаль хамгааллын тулгамдсан асуудлын нэг болов.

Аймаг бэлчээрийн томоохон мал аж ахуйтай учраас экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх бололцоо, нөөцтэй; нутаг дэвсгэрийн нэлээд хэсэг нь газар тариалангийн үйлдвэрлэл явуулахад тохиромж бүхий хөрстэй; зам, харилцаа, эрчим хүч зэрэг дэд бүтэц илүү хөгжсөн улсын гол зах зээлд хамгийн ойр дөт байдгаараа бизнесийн хувьд илүү таатай орчинтой, эрдсийн түүхий эдийн геологийн судалгаа харьцангуй сайн хийгдсэн, алт, нүүрсний томоохон орд газруудтай; аялал, жуулчлал хөгжих үндсийг бүрдүүлсэн байгалийн үзэсгэлэнт болон түүхийн дурсгалт газар олонтой, гадаад улс орны мужуудтай харилцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх дэд бүтцийн өргөн боломжтой зэрэг өөрийн давуу талдаа түшиглэн тодорхой хугацааны дотор эдийн засгаа хөгжүүлэх бүрэн боломж байгаа юм.

Хөгжлийн нөөц боломж, давуу талыг оновчтой ашиглах замаар аймгийн эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, орчин үеийн аялал жуулчлал, өндөр технологи бүхий боловсруулах аж үйлдвэрийн салбар давамгайлсан эдийн засгийн бүтцийг бий болгон хөгжүүлэх шаардлагатай байна.

Аймгийн хөгжлийн хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлохдоо аймгийн дотоод, гадаад нөхцөлд дүн шинжилгээ хийж, **хөгжлийн давуу хийгээд сул** талуудыг тодруулан авч үзсэн болно.

Төв аймгийн хөгжлийн гол стратеги нь хүнээ эрхэмлэн дээдэлсэн, байгаль орчны даац чадамжинд зохицсон, эдийн засгийн хувьд дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ тэргүүлэх үүрэгтэй, өндөр өсөлттэй, өөрийгөө тэтгэдэг, оновчтой бүтэц бүхий эдийн засагтай болох явдал мөн.

Аймгийн хөгжлийн хэтийн төлөвийг хөтөлбөрт тусгасан 2008-2016, 2017-2023 он гэсэн 2 үе шатаар авч үзэв.

**I үе шат (2008-2016 он)**-ны эцэст эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тааламжтай нөхцөл бүрдэж ДНБ жилд дундажаар 12,0 хувиас доошгүйгээр тогтвортой өсөхийн зэрэгцээ экспортын үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж, аймгийн эдийн засагт аж үйлдвэр, аялал жуулчлалын салбарын өсөлт нэмэгдэж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулагдаж, мэдлэг, мэдээллийн технологид суурилсан эдийн засгийн үндэс суурь тавигдана. Аймгийн болон нийслэл орчмын бүс, сумдад мах, сүү, хүнсний ногооны чиглэлийн эрчимжсэн фермерийн аж ахуйнууд, мал амьтаны гаралтай түүхий эд, газар тариалангийн бүтээгдэхүүнийг боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүд байгуулагдаж, хүн амын хүнсний хангамж сайжирна.

Боловсролын тогтолцоо шинэчлэгдэж, сургалтын чанар, материаллаг бааз, менежмент сайжирч, 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжинэ. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа боловсронгуй болж, оношлогоо, эмчилгээний чадавхи сайжирч, үйлчлүүлэгчдэд ээлтэй үйлчилгээний таатай орчин бүрдэж, хүртээмж, чанар нь сайжирна.

Аймгийн зам тээвэр, эрчим хүч, усан хангамжийн сүлжээ оновчтой өргөжиж, өсөн нэмэгдэж буй хэрэгцээг бүрэн хангах үндэс суурь улам сайжирна. Хөрсний элэгдэл эвдрэл, бэлчээрийн талхагдал багасаж, хог хаягдлын менежмент боловсронгуй болно. Газар хөдлөл, гал түймэр, уруйн үер, мал амьтны гоц халдварт өвчин зэрэг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх ажил сайжирч, аюулд өртсөн тохиолдолд хохирлыг харьцангуй богино хугацаанд арилгах чадавхи бүрдэнэ.

**II үе шат (2017-2023 он)**-ны эцэст аймгийн ДНБ-ний жилийн дундаж өсөлт 14,0 хувиас доошгүйгээр тогтвортой өсч, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, аймгийн эдийн засгийн бүтэц сайжирч, орчин үеийн **аж үйлдвэр -үйлчилгээ - хөдөө аж ахуй** гэсэн загварт шилжин эдийн засгийн салбарын бүтэц улам боловсронгуй болно.

Мөн ус, хөрсний бохирдол, эвдрэл, бэлчээрийн талхагдал эрс буурч хүн ам орон нутагтаа ая тухтай амьдрах таатай орчин бүрдэнэ.

Эдийн засгийн өсөлтийн үр дүнд нийгмийн болон бусад салбаруудын хүрээний зорилтууд амжилттай хэрэгжиж хүн ам тогтвортой өсч, амьдралын чанар сайжирна.

Аймгийн хөгжлийн хөтөлбөрийн бүрэн хэрэгжилтийг тооцож гаргах 2023 он нь манай аймгийн 100 жилийн ойтой хугацааны хувьд давхцаж байгаагаараа ихээхэн онцлог юм.


Аймгийн хөгжлийн хөтөлбөр нь 1) Эдийн засгийн хөгжил; 2) Нийгмийн хөгжил; 3) Байгалийн нөөц, байгаль орчны хамгааллын хөгжил, 4) Нутгийн удирдлага, эрх зүйн хөгжил, 5) Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийтлэг арга хэрэгсэл. 6) Аймгийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ үнэлгээ хийх үзүүлэлтүүд гэсэн өөр хоорондоо нягт уялдсан 6 бүлгээс бүрдэж байгаа болно. Мөн “Хөтөлбөрийг боловсруулахад ашигласан судалгаанууд” гэсэн хавсралтыг оруулав.

## НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

### 1.1. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, салбарын зохистой бүтцийг бий болгох талаар

**Үндэслэл:** Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2007 онд 95,4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 26,8 хувиар өсч, нэг хүнд 1074,2 мянган төгрөг ногдохоор тооцогдож байна.


Зураг 1.



Аймгийн хэмжээнд ХААН, Зоос, Хас, Шуудан, Анод банкны салбарууд, банк бус санхүүгийн 2 байгууллага, хадгаламж зээлийн хоршоо 12 үйл ажиллагаа явуулж, 2007 онд нийтдээ 37251 зээлдэгчид 23678,1 сая төгрөгийн бизнесийн зээлийг олгоод байгаа нь өмнөх оноос 3643,5 сая төгрөгөөр нэмэгдэж зээлийн дундаж хүү 7,1 хувиар буурчээ.

2007оны байдлаар аймагт нийт 1102 аж ахуйн нэгж бүртгэгдэж татварын бааз суурь жил бүр өсөн нэмэгдэж байна. Аж ахуйн нэгж, байгууллагууд 2007 оноос эхлэн электрон тайлангийн гэрээ хийж, санхүүгийн тайлангаа интернетээр дамжуулан нэгтгүүлж байгаа ба жилийн эцсийн санхүүгийн тайлан тушаалт 87,0 хувьтай байна.

Зураг 2.



Дотоодын нийт бүтээгдэхүүний 71,1 хувийг мал аж ахуй, газар тариалан, 28,9 хувийг үйлдвэрлэл, үйлчилгээний бусад салбар эзэлж байна.

Аймгийн төсвийн нийт зарлага 2007 оны байдлаар 17813,0 сая төгрөг ба үүний 30,4 хувь нь орон нутгийн төсвийн зарлага, 69,6 хувь нь улсын төсвийн байгууллагуудын зардал байна.

Нийт төсвийн зарлагын 40 гаруй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт, их засварын ажлыг гүйцэтгэж байна.

Орон нутгийн төсвийн зарлага нь 6555,3 сая төгрөг бөгөөд үүний 4793,3 сая төгрөг буюу 73,1 хувь нь аймаг, сумдын төсөвт төвлөрүүлэх орлогоос, үлдэх 26,9 хувь нь улсын төсвөөс авах шилжүүлгийн орлого, санхүүгийн дэмжлэг, эрүүл мэндийн даатгалын эх үүсвэрүүдээс бүрдэж байна. Аймгийн нэгдсэн төсвийн орлогын 68,3 хувийг ашигт малтмалын нөөц ашигласны болон газар, ус, ой, ан, байгалийн бусад баялаг ашигласны төлбөр, хураамжийн орлого эзэлж байна.

Өнөөгийн байдлаар манай аймаг аж үйлдвэр сул хөгжсөн, эдийн засгийн бүтэц оновчтой бусаас хөгжлийн хурдац удаан байна. Иймд бизнес эрхлэх нэн таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг хурдасгах, эдийн засгийн салбарын бүтцийг боловсронгуй болгох шаардлагатай.

**Бүх үе шат (2008-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн эдийн засгийн салбарын бүтцийг шинэчилж, боловсруулах үйлдвэрийн салбарын өсөлтийн хурдацыг түрүүлүүлэх, хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоно.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Банк, санхүүгийн үйлчилгээг өргөжүүлэх, зээлийн хүүг бууруулан бизнес эрхлэгчдийг дэмжих,
- Санхүү, банк, татвар, аудит, хяналт шалгалтын ажлын уялдаа холбоог сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх, төлөвлөлт, бүртгэл мэдээлэл, хяналтын үр дүнг дээшлүүлэн нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлыг илүү хурдацтай сайжруулах,
- Олон улсын нийтлэг арга зүйд тулгуурласан статистикийн үндэсний стандартыг мөрдөж, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, хэрэглэгчдийг чанартай мэдээлэл, шуурхай үйлчилгээгээр хангах,
- Урт хугацааны даатгалыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж хэрэгжүүлж ажиллах,
- Мэдлэгт суурилсан эдийн засаг, инновацийн тогтолцоог бүрдүүлэх
- Эдийн засгийн хөгжилд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, тогтвортой орчинг бүрдүүлж аймагт ашигтай хамтарсан үйлдвэр байгуулах санал санаачлагыг тэргүүн ээлжинд дэмжих,
- Дэлхийн улс орны хөгжлийн түвшин инновацийн идэвхижлээр тодорхойлогдоно хэмээн үзэх болсон тул үндэсний инноваци бүтээмжийн үр ашигтай эдийн засгийн тэргүүлэх салбаруудын технологи, гадаадын дэвшилтэт технологиудын ололтыг судалж үйлдвэрлэлд нэвтрүүлэх,

**Гарах үр дүн:** 2008-2016 онд эдийн засгийн өсөлтийг жилд дундажаар 12 хувьд, 2023 онд эдийн засгийн өсөлтийг жилд дундажаар 14-оос доошгүй хувьд хүргэнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Аймгийн эдийн засгийн өсөлт, төсөв санхүүгийн тогтвортой, тэнцвэрт байдлыг бататгаж, санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн хөгжлийн бодлогод зориулан оновчтой хуваарилах замаар хүн амын бодит орлого хийгээд нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн салбарын хөгжлийг дэмжихэд чиглэгдэнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Татварын орлогын бааз суурийг өргөтгөн төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх

- Татварын нэр төрөл, татвар ноогдуулах аргачлалыг олон улсын жишигт нийцүүлж, хуримтлагдсан татварын зээлийн татварын тогтолцоог хэрэгжүүлэх,
- Байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл үйлчилгээнд экологийн татварыг хуулийн дагуу ногдуулах ажлыг хэрэгжүүлэх,
- Төсвийг аймгийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан боловсруулж, хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох,
- Улсын болон орон нутгийн төсвийн уялдаа холбоог сайжруулж, төсвийн байгууллагын бодит хэрэгцээнд нийцүүлэн төлөвлөж санхүүжүүлэх,
- Төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх,

**Гарах үр дүн.** Аймгийн хөрөнгө оруулалтын хэмжээ өсч, жижиг дунд үйлдвэрийн тоо хэмжээ, ажлын байр нэмэгдэнэ.

## **1.2. Үйлдвэр, үйлчилгээний салбарын хөгжил**

**Үндэслэл:** Аймагт аж үйлдвэрийн салбар, түүний дотор жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ сул хөгжсөн. Аймгийн эдийн засагт мал аж ахуй, газар тариалан голлодог.

Аймагт 786 аж ахуйн нэгж байгаагаас 80 гаруй хувь нь үйлдвэрлэлийн чиглэлээр ажиллаж байна.

Үйлдвэрийн газрууд хувьчлагдаж, удирдлага зохион байгуулалтад өөрчлөлт орсон боловч бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, техник технологийн шинэчлэлт хийх, хүчин чадлыг бүрэн ашиглах талаар үр дүнд хүрээгүй байна.

Манай аймгийн нутаг дэвсгэрт том хэмжээний хүч чадалтай үйлдвэр аж ахуйн газар олноор байрласан хийгээд Улаанбаатар хот, аж үйлдвэрийн томоохон зангилаа болсон Налайх, Багануур дүүрэг оршиж байгаа тул аймгийн хэмжээнд том хүчин чадлын үйлдвэр, аж ахуйн газрыг байгуулахад хүндрэлтэй бөгөөд харин орон нутгийн түүхий эдийг ашиглан хүн амын өргөн хэрэгцээний болон хүнсний төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж болохуйц бага хүч чадлын үйлдвэр цехүүдийг барьж байгуулах нь зүйтэй юм.

Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2007 онд (2000 оны үнээр, зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 5066.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ. 2007 онд аймгийн нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 45.6, боловсруулах үйлдвэрлэл 26.1, ашигт малтмал олборлолт 28.3 хувийг тус тус эзэлж байна.

Мөн онд аймгийн хэмжээнд ахуйн үйлчилгээний 434 цэгт 588 хүн ажиллаж 637.6 сая төгрөгийн орлого олж 133.4 мян хүнд үйлчилсэн байна.

Манай аймаг төвийн бүсийн хэмжээнд төдийгүй улсын хэмжээнд ашигт малтмалын нөөцөөр тэргүүлэх байр суурьтай бөгөөд тэр дундаа алт, нүүрсний нөөцөөр баялаг юм.

Аймаг нь ашигт малтмалын судлагдсан орд илрэц олонтой, нөөц ихтэй тааламжтай нөхцөлд оршиж байгаа нь уул уурхайн олборлолт, үйлдвэрлэлийн томоохон төв болон хөгжих ирээдүйтэй юм.

Ойрын жилүүдэд ашигт малтмал боловсруулах, малын гаралтай түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүнсний ногоо, сүү, цагаан идээ боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар аж үйлдвэрийн салбарт өндөр өсөлтийг бий болгох шаардлагатай.

### **Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Нөөц нь тогтоогдсон ашигт малтмалын орд газруудыг байгаль орчинд хор хөнөөлгүйгээр ашиглаж, улмаар уул уурхайн боловсруулах салбарын үйлдвэрийг бий болгоно.

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**



- Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын лицензийг олгохдоо уул уурхайн бодлогыг баримталж, эхний ээлжинд ашиглах боломжтой эрдэс баялгийн ордыг байгальд хор хөнөөлгүй, зүй зохистой аргаар ашиглах;
- Уул уурхайн үйлдвэрлэлд аймгийн аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, тэргүүн ээлжинд дэмжиж, орон нутгийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах;
- Уул уурхайн боловсруулах салбарын үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг бүх талаар дэмжих
- Хүнд үйлдвэрийн салбарыг бэлэн байгаа дэд бүтцээ түшиглэн бүсчилэн хөгжүүлэх. Тухайлбал Төвийн болон зүүн бүсийн сумдын хүнд үйлдвэрийг хөгжүүлэх байршлыг 7-р зөрлөгт төвлөрүүлэх
- Аймгийн эрдэс баялгийн нөөцөд тулгуурлан эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, салбарын бүтцийг шинэчлэн өөрчлөх мастер төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;
- Аймагт барилгын материалын үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх;

**Гарах үр дүн:** Уул уурхайн үйлдвэрлэлийн хурдацтай өсөлтийн үр дүнд аймгийн ДНБ-д уул уурхайн боловсруулах салбарын эзлэх хувийн жинг зохистой хэмжээнд хүргэнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** МАА, Газар тариалангийн түүхий эдэд тулгуурласан, бие даасан тогтвортой ажиллах, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чадвартай орон нутгийн онцлогт тохирсон, боловсруулах чиглэлийн ЖДҮ-ийг буй болгоно.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Өрх бүр үйлдвэрлэгч болох;
- Сум бүрийг өөрийн гэсэн бренд бүтээгдэхүүнтэй болгох зорилгоор “**Нэг өрх-Нэг бүтээгдэхүүн**”, “**Нэг баг-Нэг бүтээгдэхүүн**”, “**Нэг сум-Нэг бүтээгдэхүүн**” хөдөлгөөн өрнүүлэх;
- Аймгийн нэрийн бүтээгдэхүүнээр шалгарсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөтгөх үүднээс төсөл хөтөлбөрийг эхний ээлжинд дэмжих;
- Зуунмод хотод холимог үйлдвэрлэлийн “Зуунмод” хөгжлийн парк байгуулах;
  - Мал, амьтны гаралтай ховор түүхий эдийг боловсруулан энзимологи, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийг хөгжүүлэн бойжуулах инкубатор-үйлдвэр;
  - Мэдээллийн технологи;
  - Биотехнологийг хөгжүүлэх инкубатор;
  - Өндөр зэрэглэлийн савхин жижиг эдлэл, ноолууран нэхмэл бүтээгдэхүүний үйлдвэр
- Биотехнологи, нанотехнологи ашиглахыг дэмжих
- Аймгийн “Жижиг, дунд үйлдвэрийн сан”-гийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, бага оврын тоног төхөөрөмжийн лизингийн үйлчилгээг өргөжүүлэх, зээлийн даатгалын үйлчилгээнд хамруулах
- Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, тэдэнд техник, технологийн сонголт хийхэд нь туслах, төсөл боловсруулах, шалгаруулах явцад нь зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий төвүүдийг бүсийн төв сумдад зохион байгуулж ажиллуулах;
- Улсын болон орон нутгийн захиалгаар санхүүжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд жижиг, дунд үйлдвэрийг түлхүү хамруулах бодлого баримтлах;
- Орон нутгийн туршлагыг харгалзан аймгийн төв болон сумдад эсгий, эсгий гутал, ноос угаах төрөлжсөн болон хоршсон үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлэх;
- Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын хэрэгцээг хангаж, дэлхийн зах зээлд өрсөлдөх сүү, сүүн бүтээгдэхүүний болон мах, ногоо боловсруулах үйлдвэр

байгуулах санал, санаачлагыг дэмжиж, үйл ажиллагааг нь тогтворжуулан төрөлжүүлж савлан экспортлохыг дэмжих;

- Малын арьс, шир, ноос ноолуур зэрэг түүхий эдийг байгаль орчинд сөрөг нөлөөгүй, шинэ дэвшилтэт техник технологиор боловсруулж гутал, дээл, нэхий эдлэл, эсгий, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөнгөн үйлдвэрийн салбарын жижиг, дунд үйлдвэрүүдийг шинээр байгуулахыг дэмжих;
- Сум бүрийг орчин үеийн техник, технологтой хүнсний цехтэй болгож үйлдвэрлэлийг хөгжүүлэн хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй хүнсээр жигд, хүртээмжтэй хангаж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх гадаад зах зээлд нийлүүлж эхлэх;

**Гарах үр дүн:** ЖДҮ тогтвортой өсч аймгийн хэрэгцээт бүрээгдэхүүний 50 хувийг хангана.

**Тэргүүлэх зорилт 3.** Аймгийн худалдаа, үйлчилгээний салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Бөөний худалдааны сүлжээг бүсийн төв сумдад бий болгох;
- Худалдаа, үйлчилгээний захуудыг төрөлжүүлж, стандартын шаардлага хангасан байртай болгон орчныг тохижуулах,
- Худалдааны салбарт интернет худалдаа, төлбөр тооцоог картаар хийх хэлбэрийг нэвтрүүлэх;
- Зорчигч тээврийн үйлчилгээний ая тухтай орчин бүрдүүлэх зорилгоор Зуунмод хотын микроавтобус болон таксины зогсоолыг шинэчлэн “Тээвэр үйлчилгээний төв” болгох,
- Аймгийн төвд өндөр зэрэглэлийн зочид буудал, супермаркет байгуулж үйл ажиллагаа явуулахыг бүх талаар дэмжих
- Үйлчилгээний ажилтнуудыг давтан сургах, мэргэшлийн түвшинг нь дээшлүүлэх,
- Худалдаа, үйлчилгээний газруудын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын байгууллагууд, иргэдийн зүгээс тавих хяналтыг сайжруулах;
- Сум бүрийг ахуйн үйлчилгээний төвтэй болгож, үйл ажиллагааг тогтмолжуулах,
- Худалдааны захиалгат үйлчилгээг бий болгож зөв сонголт, соёлтой хэрэглээг хэвшүүлэх,
- Өргөн сонголт бүхий нийтийн хоолны болон зочид буудлыг бий болгож соёлтой үйлчилгээг нэвтрүүлэх, сумдын бүсийн төвүүдийг түшиглэн стандартын шаардлага хангасан нийтийн хоолны иж бүрдэл бүхий төвүүдийг байгуулан ажиллуулахыг дэмжих

**Гарах үр дүн:** Бүх төрлийн худалдаа, үйлчилгээний чанарын түвшин дээшилнэ.

**Хоёрдугаар үе шат (2017-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** ДНБ-д аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Орон нутгийн түүхий эдэд тулгуурласан томоохон үйлдвэрийг бүсчилэн зохион байгуулах.
- Үйлдвэрлэлд орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх;
- Уул уурхайн үйлдвэрлэлийн жигд тогтвортой өсөлтийг хангах;
- Зуунмод хотод шингэрүүлсэн шатдаг хийн станц барих замаар эрчим хүчний хангамжийг сайжруулах;

- Махны үйлдвэрлэлтэй уялдуулан арьс ширийг стандартын дагуу ангилан бэлтгэх, арьс, ширэн болон савхин эдлэл, гутал, хувцас, тоноглол хэрэглэлийн үйлдвэрлэлийг өргөтгөн хөгжүүлэх;
- Ноос, ноолууранд анхан шатны болон гүнзгийрүүлсэн боловсруулалт хийж, дотоодын хэрэгцээг хангахын зэрэгцээ экспортын баримжаатай үйлдвэрүүдийг хөгжүүлэх;

**Гарах үр дүн:** Аймгийн эдийн засагт аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жин 20 хувьд хүрнэ.

### **1.3. Хөдөө аж ахуйн хөгжил**

**Үндэслэл:** Аймаг 2007 оны эцэст 2626.5 мянган толгой малтай болсон. Нийт сүрэгт тэмээ 0.1, адуу 8.2, үхэр 6.0, хонь 47.6, ямаа 38.1 хувийг тус тус эзэлж байна. Сүүлийн жилүүдэд малын тоо толгой нийт дүнгээрээ өсч байгаа ч тэмээний тоо жил дараалан буурч, харин ямааны өсөлт хурдацтай явагдаж сүрэгт эзлэх хувийн жин өндөрсөн нь, сүргийн бүтцэд муугаар нөлөөлөх боллоо.

2007 оны эцэст сүү, махны чиглэлийн үхэр, махны чиглэлийн хонь, ноолуурын чиглэлийн ямааны цэвэр үүлдрийн болон эрлийз 80.6 мянган толгой, цөм сүргийн 99.2 мянган толгой малтай болов. Сүүний болон бусад эрчимжсэн мал аж ахуйн 190 гаруй ферм үйл ажиллагаа явуулж байна. Сүүний чиглэлийн үхэр, ноолуурын чиглэлийн ямаа, махны чиглэлийн нутгийн шилмэл омгийн хонины үржлийн аж ахуйд шинээр байгуулагдан ажиллаж байна.

Аймаг жилд хонины ноос 1374.0 тн, тэмээний ноос 12.6 тн, ямааны ноолуур 250.7 тн, ямааны ноос 100.3 тн, адуу, үхрийн хөөвөр 74.4 тн-ыг тус тус бэлтгэх боломжтой.

Манай аймагт сүү, махны чиглэлийн үхэр, гахай, шувуу, зөгийн аж ахуй зэрэг эрчимжсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх боломжтой.

2007 оны байдлаар 36934 га талбайд тариалалт явуулж 25620 га-д уринш боловсруулсан нь эзэмшиж байгаа талбайн 54 хувь болж байна.

Иймд аймгийн ХАА-н салбарыг эрчимжүүлж, энэ салбарын хөгжилд чанарын өсөлт гаргах шаардлагатай. Тухайлбал, дэлхийн зах зээлд үнэ, өртөг өндөр, цаг уурын нөхцөлд тохирсон таримал тарих шаардлагатай.

### **Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангана.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Малчдыг орон сууц, гэрэл цахилгаан, холбооны хэрэгслээр хангах асуудлыг үе шаттай хэрэгжүүлэх
- Малчдад чиглэсэн албан бус сургалтыг үе шаттай зохион байгуулж, малчдын залуу халааг сургаж, мэргэжилтэй малчдыг бэлтгэх;
- Бэлчээрийн мал маллагаанд нутгийн үүлдрийн малыг өөр дотор нь шилж сонгон цэвэр үржүүлгийн аргыг хэрэглэхээс гадна өндөр ашиг шимт үүлдэр, омгийн малаар эрчимжсэн мал аж ахуйг сайжруулах ажлыг хэрэгжүүлэх;
- Үхрийг мах, сүүний, ямааг ноолуурын, хонийг мах, ноосны, адууг мах, сүү, хурдны чиглэлээр сонгон үржүүлж, эрчимжсэн фермерийн болон хагас суурин аж ахуй байгуулж эрхлэхийг дэмжих;
- Шилмэл малын үзэсгэлэн худалдааг аймаг, сумын түвшинд зохион байгуулж, үржлийн шилмэл хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулж бэлтгэн нийлүүлэх;
- Цөм сүрэг, цэвэр эрлийз малын тоо толгойг жил бүр өсгөж, гүн хөлдөөсөн болон хөврөл үрээр хээлтүүлэг явуулж, өндөр ашиг шимт малын сүрэгт эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх;
- Аймгийн бэлчээрийн менежментийн зураглал гарган хэрэгжүүлэх;

- Бэлчээрийн даацад тохируулан малын тоо толгойг тогтвортой байлгах бодлого хэрэгжүүлэх;
- Малын тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлэх, улмаар өндөр ашиг шимт малыг тэжээх тэжээл үйлдвэрлэх, тариалалтанд ашиглах төрөл бүрийн био бордоо үйлдвэрлэж байгаа арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх;
- Бэлчээрт ашиглагдахгүй байгаа хуучин худаг, услалтын системүүдийг сэргээн засварлах;
- Бэлчээр ашиглалтыг сайжруулахын тулд ердийн хөсөг ашиглах уламжлалыг сэргээх
- Тэжээлийн үйлдвэрийн тоо, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж, байгалийн хадлан бэлтгэх ажлыг бодлого, төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх
- Сум дундын отрын бүс нутгийг нарийвчлан тогтоож, хамгаалалтанд авах, нөхөн сэргээх, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах
- Уламжлалт бус аж ахуй болох гахай, тахиа, зөгий, туулайн аж ахуй, фермийн тоог жил бүр нэмэгдүүлэх;

**Гарах үр дүн:** Нэгжийн ашиг шимийн гарц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэнээр малчдын ахуй амьдрал дээшилнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Хөдөө аж ахуйн хоршоо, фермерийн аж ахуйг эрчимтэй хөгжүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл, фермерийн аж ахуйг дэмжих;
- Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, ферм, малын тоог нэмэгдүүлэх;
- Мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулж, “Малын чанар сайжруулах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Мал аж ахуй ,газар тариалангийн үйлдвэрлэлийг хослон эрхэлж байгаа аж ахуйн нэгж , иргэдийн үйл ажиллагааг дэмжих

**Гарах үр дүн:** Хөдөө аж ахуй дахь хамтын хөдөлмөр сайжирч, фермерийн аж ахуй 380-д хүрч үйлдвэрлэл нэмэгдэнэ.

**Тэргүүлэх зорилт 3.** Мал, амьтныг эрүүлжүүлэх ажлыг сайжруулж, хил дамжин халдварладаг халдварт өвчинтэй тэмцэх арга механизмыг боловсронгуй болгоно.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зорилгоор мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээний ажлыг боловсронгуй болгож, мал эмнэлгийн лабораторийг олон улсын стандартад нийцүүлэх;
- Мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, ажил үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авах;
- Мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийн материаллаг бааз, эмийн нөөц хангамжийг сайжруулах, боловсон хүчнийг чадавхижуулах;
- Аймгийн мал эмнэлгийн шинжилгээний лабораторийн материаллаг бааз тоног төхөөрөмжийн хангамж, хүрэлцээ, оношлогооны чадавхийг дээшлүүлэх;
- Халдварт өвчний бүртгэгдсэн голомтуудыг байр зүйн зураглалд оруулан бүрэн хяналтанд авч цомхотгох;
- Мал эмнэлгийн анхан шатны мэдлэг, мал маллагааны уламжлалт эмчилгээний арга , паразиттах өвчнөөс сэргийлэх арга ажиллагаанд малчид иргэдийг сургах

**Гарах үр дүн:** Мал эрүүлжиж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах нөхцөл бүрдэж хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөлөл эрс буурна.

- **Тэргүүлэх зорилт 4.** Газар тариаланд улаан буудайн үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг нэмэгдүүлж, улсын хэмжээний үйлдвэрлэлийн 20 иос доошгүй хувийг үйлдвэрлэдэг болно.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Атрын 3 дахь аяныг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ашиглаагүй байгаа тариалангийн талбайг эргэлтэнд оруулан, ашиглаж байгаа талбайн хэмжээг нэмэгдүүлэх;
- 2006-2015 онд хөгжүүлэх газар тариалангийн бодлогыг хэрэгжүүлэх
- Өндөр хүчин чадалтай олон удаагийн үйлдлийг нэг явалтаар гүйцэтгэдэг орчин үеийн техникийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- Хүнсний ногооны талбайг бүрэн усалгаатай болгох;
- Үр үржүүлгийн аж ахуйн нэгжүүдийг байгуулах ;
- Хүлэмж, жимс, жимсгэнэ, зоорийн аж ахуйг бодлого төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх;
- Хөрсний үржил шимийг дээшлүүлэх нөхөн сэргээх зорилгоор биобордооны үйлдвэрлэлийг дэмжих байгальд ээлтэй экологигсон технологи нэвтрүүлэх;
- Таримал ургамлыг өвчин хортноос сэргийлэх, ургац нэмэгдүүлэх үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх;
- Эзэмшсэн талбайгаа бүрэн ашигласан, нэгж талбайгаас өндөр ургац авсан иргэд аж ахуйн нэгжийг урамшуулах арга хэмжээ авах;
- Газар тариалангийн үйлдвэрлэлийн эрсдэлийг бууруулан, 1 га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх;
- Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хослон эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд техник, тоног төхөөрөмжийг урт хугацааны бага хүүтэй зээл (лизинг)-ээр олгохыг дэмжих;
- Усалгаатай газар тариалан эрхлэх бүс нутаг тогтоож, усны хайгуул хийх
- Газар тариаланд мөөг тариалах боломжийг судлан нэвтрүүлэх;
- Багсармал, холимог, хорголжин болон бичил язгуур махбодын бүрэн найрлагат эрдэс тэжээлийн үйлдвэр байгуулж, төрөл бүрийн тэжээл үйлдвэрлэж байсан уламжлалыг тусгай бодлогоор сэргээх;
- Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах

**Гарах үр дүн:** Газар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой өсч, хүн амын хүнсний бүтээгдэхүүний хангамж сайжирна.

**Хоёрдугаар үе шат (2017-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн ХАА-н салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг 10 хувьд хүргэнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Малчдын үйлдвэрлэл, борлуулалт, фермерийн үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих;
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн мэдээллийн оновчтой тогтолцоог бий болгох;
- Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортыг үе шаттай бууруулж, эцсийн бэлэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх;
- Бэлчээр ашиглалтын менежментийг улам боловсронгуй болгох;
- Төв суурин газрын дэргэд мал аж ахуйн гаралтай болон сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг байгуулж ажиллуулах;
- Мах, сүү, ноос, ноолуурын чиглэлийн үүлдэр, омог, гойд ашиг шимт малыг биотехнологийн аргаар үржүүлэх ажлыг эрчимжүүлэх

- Малын тэжээл үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, борлуулах оновчтой тогтолцоог бүрдүүлэх;
- Байгалийн гэнэтийн аюулаас сэргийлэх, хохирлыг бууруулах зорилгоор малыг даатгалд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах;
- Газар тариаланд орчин үеийн техник технологийг өргөнөөр нэвтрүүлж, га-аас авах ургацын хэмжээг тогтвортой нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
- Өндөр технологийн болон оюуны шингэц бүхий бага оврын техник, тоног төхөөрөмжийн импортыг дэмжих.
- Буудайн үрийг сортын үрээр шинэчилж дуусгах
- Усалгаатай тариаланг 2500 га-д хүргэх
- Техникийн шинэчлэлийг бүрэн хийх
- Хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх;
- Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгох үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх;
- Сумын мал эмнэлгүүдийн лабораторийн материаллаг бааз, багаж тоног төхөөрөмжийн хангамж, оношлогооны чадавхийг сайжруулах;

**Гарах үр дүн:** Аймгийн ХАА-н салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлт 10 хувьд хүрнэ.

Эрчимжсэн фермерийн аж ахуй нэмэгдэж, тариаланчид, малчдын амьдрал ахуй дээшилнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Бэлчээрийн даац хүрэлцээг сайжруулж, ашиглалт хамгаалалтын цогц арга хэмжээ авна.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Бүх төрлийн худаг засварлах, шинээр барих ажлыг гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дэмжих;
- Зарим сумдад үерийн хөв, далан байгуулах ажлыг эрчимжүүлж, бэлчээр усжуулалтын түвшинг дээшлүүлэх;
- Эдийн засгийн урамшууллын хөшүүргүүдийг хэрэглэн бэлчээрт худаг гарган ашиглах үүсгэл санаачлагыг тууштай дэмжих;
- Бэлчээрт олон наст ургамал тариалах
- Бэлчээрийн эрсдэлийн болон гамшгийн менежментэд малчид, тариаланчид, жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийг сурган дадлагажуулах;
- Мал сүргийг индексжүүлсэн даатгалд бүрэн хамруулах;
- Дотоодод үйлдвэрлэж ашиглаж байгаа төрөл бүрийн биобордоо, багсармал болон гумины бордооны хангалт, хэрэглээг нэмэгдүүлэх;

**Гарах үр дүн:** Бэлчээрийн усан хангамжийн түвшин 80 хувьд хүрч бэлчээрийн даац сайжирна.

## **1.4. Дэд бүтцийн хөгжил**

### **1.4.1. Зам тээврийн хөгжил**

**Үндэслэл:** Төрөл бүрийн замын сүлжээний хангамжийн үнэлгээгээр манай аймаг (1.46) бүсийн хэмжээнд Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн дараа орох ба улсын хэмжээнд харьцангуй сайн замын сүлжээтэй аймгуудын тоонд орж байна. Энэ нь манай улсын төмөр замын болон сайн чанарын авто замын гол тэнхлэг манай аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөгтэй холбоотой юм.

Аймгийн зам харилцааны сүлжээ нь бусад аймгуудтай харьцуулбал онцлог бөгөөд улс орны тээврийн зангилааны гол төв Улаанбаатар хотоос бусад аймгуудын төвтэй

холбогдсон улсын чанартай авто зам 7 чиглэлээр аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөг, улсын чанартай авто замын 41 хувь нь, орон нутгийн чанартай авто замын 5,2 хувь нь хатуу хучилттай, Улаанбаатар хоттой Зуунмод сум хатуу хучилттай 45 км авто замаар холбогдсон.

Автозамын хөгжлийн түвшин 2000-2007 онуудад эрчимтэй хөгжлийн үе байсан бөгөөд энэ хугацаанд улс болон хот хоорондын чиглэлийн 829 км замаас 647 км буюу 78,0 хувь нь стандартын шаардлага хангасан хатуу хучилттай болжээ. Улс болон хот хоорондын авто замаар дамжин өнгөрч байгаа хөдөлгөөний эрчмийн судалгааг 2000-2007 онуудад хийхэд авто замын хөгжлийг дагаж тээврийн хэрэгслийн тоо эрс өсч, үндсэндээ иргэдийн амьдрал сайжирсан эерэг дүн гарч байна.

Жилд дунджаар 120,0 орчим сая төгрөгний зам гүүр засвар арчлалт, тэмдэгжүүлэлтийн ажил хийгдэж байгаа бөгөөд хөрөнгийн төвлөрөлт жил бүр 5,0 хувиар нэмэгдэж байна. Цаашид орон нутгийн чанартай замын зэрэглэлийг нэмэгдүүлэх талаар шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### **Нэгдүгээр үе шат (2008-2016он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн авто замын сүлжээг сайжруулна.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Аймгийн автозамын салбарыг автозамыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөртэй уялдуулан хөгжүүлэх;
- Автозамын салбарыг хөгжүүлэхэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөс гадна гадаадын хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг бүх талаар урамшуулан ашиглах;
- Аймгийн авто замын нэгдсэн сүлжээний зураглалыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх;
- Улаанбаатар-Зуунмод чиглэлд хурдны зам байгуулах;
- “Мянганы зам”-ын хэвтээ тэнхлэгийн Лүн-Улаанбаатарын автозамыг шинэчлэх;
- Өндөр-Дов – Дундговийн хатуу хучилттай авто замыг барих;
- Аялал жуулчлалын гол цэгүүдийг төв замтай хатуу хучилттай замаар холбох;
- Зуунмод хотын авто замыг шинэчлэн, орон сууцны гаднах зам талбайн тохижилтыг хийх;
- Зуунмод –Манзуширын хатуу хучилттай автозамыг барих;
- Улс болон хот хоорондын зам дагуух буюу томоохон сумдын (Баян, Лүн, Эрдэнэсант, Баянхангай, Баянчандмань, Эрдэнэ)-төвийг хатуу хучилттай авто зам, талбайтай болгох;
- Борнуур, Жаргалант, Сүмбэр сумдын төв замтай холбогдсон автозамыг шинэчлэх;
- Гол, намаг,жалга судганд төмөр бетонон хоолой, хайрган зам барьж туулах чадварыг нэмэгдүүлэх;

**Гарах үр дүн:** Аймгийн төрөл бүрийн замын сүлжээний хангамж эрс сайжирна.

**Тэргүүлэх зорилт 2.** Зам, гүүрийн барилгын техник, технологийг байгальд халгүй, эдийн засгийн өндөр үр ашиг бүхий орчин үеийн шилдэг загварын машин техникээр шинэчилнэ.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Зам, гүүрийн барилгын техник хэрэгслийн хангамжийг урт хугацааны бага хүүтэй зээл (лизинг)-ээр дэмжин сайжруулах;

- Баянчандмань, Зуунмод, Баян, Эрдэнэ, Лүн сумдад асфальт болон төмөр бетон үйлдвэрлэл явуулах суурин заводыг байгуулах;
- Нүүдлийн асфальт бетон заводыг Зуунмод хотод байгуулах;

**Гарах үр дүн:** Аймгийн хэмжээний зам барилгын байгууллагуудын чадавхи, бүтээмж, ашигт ажиллагаа сайжирсан байна.

**Тэргүүлэх зорилт 3.** Агаарын тээврийн үйлчилгээг өргөтгөн сайжруулна.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Сэргэлэн сумын Хөшгийн хөндийд олон улсын нисэх онгоцны буудал байгуулах
- Агаарын тээврийн үйлчилгээний хүртээмж, тогтвортой, найдвартай байдал, ая тухыг бүрдүүлэх;
- Олон улсын зорчигч болон ачаа тээврийн онгоц хүлээн авах нөхцлийг бүрдүүлэн, шууд харилцаат Япон улсын Тоттори муж, БНСУ-ын Ганвон муж зэрэгтэй агаарын замын шугам нээх асуудлыг шийдвэрлүүлэх;

**Гарах үр дүн:** 3600 метр зурвас бүхий жилд 1,6-1,8 сая хүнд үйлчлэх хүчин чадал бүхий олон улсын нисэх онгоцны буудалтай болно.

**Тэргүүлэх зорилт 4.** Аймгийн авто тээврийн логистик системийг бий болгоно.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Мянганы замын босоо буюу хэвтээ тэнхлэгийн дагуу улс хоорондын тээврийн коридор бий болгох.
- Улс хоорондын тээврийн коридор бий болгосны дагуу оношлогооны болон засвар үйлчилгээний Автосервис үйлчилгээг Баян, Эрдэнэ, Баянчандмань, Лүн сумдад бий болгох.
- Орон нутгийн болон хот хоорондын нийтийн тээврийн авто аж ахуйг байгуулан хэрэглэгчдийн эрх ашигт нийцсэн, байгаль орчинд сөрөг нөлөөгүй тээврийн хэрэгслээр парк шинэчлэх.
- Авто аж ахуй, зохицуулагч, зуучлагч үйлчилгээ, оношлогооны болон ачих, буулгах логистик системийг Зуунмод, Баян, Эрдэнэ, Эрдэнэсант сумдад бий болгон, төлөвшүүлэх;

**Гарах үр дүн:** Тээврийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болох үндэс суурь тавигдана.

**Хоёрдугаар үе шат (2017-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Улс болон хот хооронд, орон нутаг, түүнчлэн аялал жуулчлалын авто замыг хөгжүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Мянганы авто замын туулах чадварыг нэмэгдүүлнэ.
- Аялал жуулчлалын баазыг авто замаар холбоно.

**Гарах үр дүн:** Аймгийн авто замын орчин үеийн нэгдсэн сүлжээ бий болно.



**Тэргүүлэх зорилт 2.** Агаарын тээврийн үйлчилгээг өргөтгөн сайжруулна.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Агаарын тээврийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, нислэгийн аюулгүй байдлыг ханган, нислэгийн тоо, чиглэлийг үйлчлүүлэгчдийн эрх ашигт нийцүүлэн зохион байгуулах;

**Гарах үр дүн:** Агаарын тээврийн үйлчилгээ шинэ шатанд гарна.

**Тэргүүлэх зорилт 3.** Аймгийн бүх төрлийн тээврийн үйлчилгээний оновчтой сүлжээг бий болгоно.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Олон улсын TIR конвенцид нэгдэх;
- Орон нутагт автотээврийн Логистик системийн төлөвшилтийг бүрэн хэрэгжүүлэх;

**Гарах үр дүн:** Тээврийн үйлчилгээний орчин үеийн сүлжээ бүрдэнэ.

#### **1.4.2. Эрчим хүчний салбарын хөгжил**

**Үндэслэл:** Манай аймгийн хувьд бүх сумын төв төвлөрсөн цахилгаан хангамжийн сүлжээнд холбогдсон. Хөдөөгийн малчин өрхүүдэд нар, салхины эх үүсвэрийг ашиглах ажил эрчимжиж, аймгийн нийт малчин өрхийн 48.4 % нь нар, салхины эх үүсвэрээр хангагдсан байна. Нар, салхины эх үүсвэрүүдийг ашигласнаар хөдөөгийн малчин өрхийн цахилгааны хангамжийг нэмэгдүүлж болох юм.

Зуунмод суманд дулааны цахилгаан станц байгаа боловч суурилуулсан тоног төхөөрөмжүүд нь хоцрогдсоны улмаас ашиглаж болохгүй, ашигласан тохиолдолд эвдэрэл гэмтлийг үед засаж сэлбэх тоног төхөөрөмж олдохгүй зэргээс шалтгаалан консервацид тавьсан байна. Зуунмод сум халаалтын 9 зуухтай бөгөөд энэ нь ойрын хугацаанд эрэлт хэрэгцээг хангаж чадах боловч цаашид зайлшгүй өргөтгөл хийх шаардлагатай.

Баянчандмань, Батсүмбэр, Угтаал, Аргалант, Заамар зэрэг 5 сум төвлөрсөн халаалтын системтэй, бусад сумдын байгууллага тус бүрт бага оврын зуух суурилагдсан байна. Сумдад ашиглагдаж байгаа зуухнуудын олонх нь ОХУ-д үйлдвэрлэсэн БЗУИ-100, НР-54 загварын зуухнууд болон БНХАУ-д үйлдвэрлэсэн RJG маркийн болон бусад бага оврын зуухнууд байна.

Дулааны эрчим хүчний үнэ тарифыг зөвхөн орлогоороо зарлагаа нөхөх байдлаар хэт доогуур тогтоож ирсэн, дулаан үйлдвэрлэгчид нь тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх үйл ажиллагааны зардалд хөрөнгө гаргаж чадахгүй байгаагийн улмаас үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангаж чадахгүй байгаа Цаашид үнэ тарифын бүтцэд өөрчлөлт оруулж, өртөг зардлыг бүрэн нөхөхүйц шинэ үнэ тогтоох хэрэгцээтэй байна. Дээрх байдал нь эрчим хүчний салбар дахь өнөөгийн хамгийн тулгамдсан зорилт юм.

#### **Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Бие даасан, тогтвортой, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чадвартай эрчим хүчний салбарыг буй болгоно.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

## **Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр (2008-2023 он)**

- Хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоолсны үндсэн дээр эрчим хүчний салбарын шинэчлэл, хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлж сумдын халаалтын тогоонуудад шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, тоног төхөөрөмжийг нь иж бүрэн шинэчлэх техникийн шинэчлэл хийх;
- Аймгийн төв Зуунмод хотод төвлөрсөн дулааны станц байгуулах;
- Эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх шаардлагатай төслүүдийг хувийн хөрөнгө оруулалт татах замаар шийдвэрлэх;
- Салхит ууланд салхин станц байгуулах нарийвчилсан хэмжилт судалгаа хийж, улмаар дунд хүчин чадлын салхин парк байгуулж ашиглалтад оруулах;

**Гарах үр дүн:** Аймгийн эрчим хүчний систем өргөжин, эрчим хүчний хангамж жигд сайжирна.

**Тэргүүлэх зорилт 2.** Агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн эрчим хүчний зохистой хэрэглээг буй болгоно.

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Хот суурин газрын айл өрхийн зуухыг сайжруулах замаар агаарын бохирдлыг бууруулах;
- Аймгийн төвийн гэр хорооллын 5, 6-р багуудын өрхүүдийг төвлөрсөн халаалтын системд холбох;
- Үр ашигтай, байгальд халгүй дулааны зуух, цахилгаан тоног төхөөрөмжийг үйлдвэрлэл, ахуйд нэвтрүүлэх;
- Шинэ төрлийн шатахууныг дулааны үйлдвэрлэлд өргөнөөр нэвтрүүлэх шингэрүүлсэн хий, шахмал түлш, кокс гэх мэт;
- Хөдөөгийн малчин өрхийн 70-аас доошгүй хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах ажлыг дэс дараатай хэрэгжүүлэх;

**Гарах үр дүн:** Байгаль орчинд халгүй эрчим хүчний зохистой хэрэглээ бий болно.

## **Хоёрдугаар үе шат (2017-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Эрчим хүчний менежментийг боловсронгуй болгож, байгаль орчинд халгүй тэргүүний техник технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашгийг дээшлүүлнэ.

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Эрчим хүчний хангамжийг өртөг багатай, найдвартайгаар зохион байгуулахын тулд сумдад дулааны эрчим хүчний нэгдсэн систем бий болгож, бага оврын халаалтын зуух бүхий хэрэглэгчдийг түүнд холбох;
- Аймаг нүүрсний уурхайтай болох асуудалд онцгой анхаарч, энэ чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулах;
- Аймаг, сумдын нэвтрүүлэх чадвар нь хүрэлцэхгүй байгаа, хуучирсан дулааны шугам сүлжээг өргөтгөх;
- Хөдөөгийн малчин өрхийн 90-аас доошгүй хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах ажлыг дэс дараатай хэрэгжүүлэх;
- Барилга байгууламжид өргөнөөр ашиглагдаж байгаа нарны илчээр ус, агаар халаах арга, технологи, тоног төхөөрөмжийг хэрэглээний халуун ус болон бусад зориулалтаар өргөн ашиглах;
- Дулааны станцыг нүүрс боловсруулах үйлдвэртэй хослуулан ажиллуулж хийн шаталттай системд шилжүүлэх.

**Гарах үр дүн:** Аймгийн эрчим хүчний системийн үйл ажиллагаа жигдэрч, ашигт ажиллагааны түвшин дээшилнэ.

### **1.4.3 Мэдээлэл, харилцаа холбооны хөгжил**

**Үндэслэл:** Холбоо ашиглалтын орлого 2007 онд 319.6 сая.төг болж өмнөх оноосоо 11.5 хувиар буурчээ.

Монгол шуудангийн салбарын үйлчилгээний орлого 40.8 сая.төг болж, нийт орлогын 84.5 хувь нь хүн амд үйлчилсний орлого эзлэж байна. Нийт орлогын 13.3 хувийг албан бичгийн, 10.0 хувийг зорчигчдын, 52.0 хувийг хэвлэлийн шимтгэлийн орлого эзлэх болов.

Аймаг дахь үүрэн телефоны Мобикомын салбар 1.772.0 сая.төг-ийн үйлчилгээ хийж, 9160 хэрэглэгчтэй; Скайтелийн салбар 131.6 сая.төг-ийн үйлчилгээ үзүүлж, 3288 хэрэглэгчтэй; ЖиМобайлын салбар 59.9 сая.төг-ийн үйлчилгээ үзүүлж, 606 хэрэглэгчтэй; Юнителийн салбар 63.7 сая.төг-ийн үйлчилгээ үзүүлж, 590 хэрэглэгчтэй болсноор, аймгийн нийт хэрэглэгчдийн тоо 13644-т хүрчээ.

Холбооны үйлчилгээнд хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулах, мэдээллийн технологийг айл өрхөд хүргэх, холбоо мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, хиймэл дагуулын болон бага багтаамжийн радио релейн шугам, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулах шаардлагатай байна.

### **Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Цахилгаан холбооны суурь, сүлжээг шинэчилж шилэн кабелийн сүлжээнд холбож аймаг, сумын хооронд дамжуулах системийн тоон технологит бүрэн шилжүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- “Цахим Монгол” хөтөлбөр”, “Хөдөөгийн цахилгаан холбоог 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө (2003)”, “Шуудангийн салбарыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө (2003)”-г хэрэгжүүлэх;
- Аймгийн бүх сумдыг хамарсан нийтэд хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны өндөр хурдны сүлжээ байгуулах;
- Аймгийн төвд телевизийн дахин дамжуулах станцыг хүчин чадлыг нэмэгдүүлж, нэвтрүүлгийн чанарыг сайжруулах;
- Үүрэн телефон хэрэглэгчдийн хүрээг өргөтгөх;
- Айл өрхийг компьютержуулах арга хэмжээ авах;
- Бүх сумдад интернетийн сүлжээг бүрдүүлж, компьютер, интернет хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх;
- Нэгдсэн код (ZIP) бүхий шуудангийн хаягийн системийн хамралтыг нэмэгдүүлэх;
- Бүх малчид, сумын төв суурин газруудад олон сувгийн нэвтрүүлэг үзэх боломжтой болгох;
- Аймгийн мэдээлэл технологийн төвийн статус, үйл ажиллагааг өргөжүүлж Мэдээлэл технологийн газар болгон зохион байгуулж, аймгийн Мэдээлэл технологийн ордон, парк байгуулах;
- Орон нутгийн телестудийг аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан мэргэжлийн телевиз болгон хөгжүүлэх бүх сумдад 20-оос доошгүй сувгийн телевизийн нэвтрүүлэг үзэх боломж нөхцлийг бүрдүүлэх;
- Орон нутгийн сонин хэвлэлийг хөхүүлэн дэмжиж, өөрийн сонин хэвлэлийн үйлдвэртэй болгон чанар хүртээмжийг дээшлүүлэх, гадаадын зарим оронд тухайн хэл

дээр тогтмол хэвлэгддэг хэвлэлтэй болж, аймгаа сурталчлах ажлыг шинэ шатанд гаргах;

**Гарах үр дүн:** Бүх сум мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн сүлжээнд 100 хувь холбогдсон байна.

### **Хоёрдугаар үе шат (2017-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Холбооны үйлчилгээнд тоон системийг бүрэн нэвтрүүлж, хиймэл дагуулын болон бага багтаамжийн радио релейний шугам, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулна.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**

- Орон нутгийн мэдээлэл, холбооны сүлжээний технологийн шинэчлэлтийг дуусгах;
- Үүрэн телефон хэрэглэх сонирхолтой хүн амын хэрэгцээг бүрэн хангах;
- Интернетийн сүлжээг сум, багийн түвшинд өргөтгөж, компьютер, интернет хэрэглэгчдийн хэрэгцээг бүрэн хангах;

**Гарах үр дүн:** Мэдээлэл харилцаа холбооны орчин үеийн оновчтой сүлжээ бий болсон байна.

### **1.5. Аялал, жуулчлалын салбарын хөгжил**

**Үндэслэл:** Зуунмод сум нь Монгол орны аялал жуулчлалын тэргүүлэх онцгой бүс болох Улаанбаатарын бүс буюу нийслэл хотоос 45 км зайтай байрладаг, дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн, байгаль, түүх, соёлын аялал жуулчлал хөгжүүлэх нөөц, боломж ихтэй.

Монгол орны аялал жуулчлалын гол бүсийн нэг нь манай аймаг бөгөөд сүүлийн жилүүдэд аялал жуулчлал эрхлэгч аж ахуйн нэгжүүд олноор бий болж байна.

Монгол орны онгон байгаль гадаадын төдийгүй өөрийн орны жуулчид, аялагчдын сонирхлыг ихээр татах болж сүүлийн жилүүдэд гадаад, дотоодын жуулчдын тоо эрчимтэй нэмэгдэв.

Төв аймгийн нутаг дэвсгэрт одоогоор Улаанбаатар хотын болон өөрийн аймгийн жуулчны 53 бааз үйл ажиллагаа явуулж, Монгол улсад ирсэн жуулчдын 59 хувь нь манай аймагт ирж, 80 хувь нь аймгийн нутаг дэвсгэрээр зорчин өнгөрч байна.

Цаашид байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэхэд сурталчилгаа, судалгааны ажлыг түлхүү хийж, рашаан сувилалд түшиглэсэн дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна.

### **Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Аялал жуулчлалыг аймгийн эдийн засгийн бие даасан салбарын хэмжээнд хүргэж оновчтой хөгжүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Аялал жуулчлалыг байгалийн, одон орны, түүх, соёлын, ан агнуурын гэх мэтээр төрөлжүүлэн хөгжүүлэх;
- Дотоод, гадаадын жуулчид, анчдыг хүлээн авах олон улсын зэрэглэлийн зочид буудал, жуулчдын баазын сүлжээ байгуулах;
- Байгальд халгүй, орчин үеийн технологид суурилсан эрчим хүчний эх үүсвэрээр жуулчны үйлчилгээний газруудыг хангах арга хэмжээ авах;

### **Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр (2008-2023 он)**

- Аялал жуулчлалын салбарт гадаадын сонирхогч томоохон компаний хөрөнгө оруулалтыг татан оруулах арга хэмжээг зохион байгуулах;
- Дотоодын аялал жуулчлал хөгжүүлэх үүднээс жуулчдын бааз болон бусад амралт сувиллын газруудыг тохижуулж, хүчин чадлыг нь бүрэн ашиглах нөхцөл бүрдүүлэх;
- Манзуширт шашин соёлын “Үндэсний цогцолбор” байгуулах;
- Орон нутгийн онцлогт тохирсон шинэ аялалын төрлүүдийг бий болгох;
- Аялал жуулчлалын хугацааг уртасгахад анхаарч, өвлийн улиралд жуулчин хүлээн авдаг жуулчдын баазын тоог нэмэгдүүлэх;
- Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Төвийн бүсийн аймгуудын олон ястны соёл урлаг, ардын өв уламжлалыг харгалзан бүсийн тулгуур төв Зуунмод хотод Төвийн бүсийн соёл урлагийн болон спортын төв цогцолбор, байгууламжуудыг барих;

**Гарах үр дүн:** Аялал жуулчлалын салбар түргэн хурдацтай хөгжих үндэс суурь тавигдаж, эдийн засагт тус салбарын эзлэх байр суурь нэмэгдэнэ.

### **Хоёрдугаар үе шат (2017-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлж, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэнэ.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**

- Аймгийн шууд харилцаат мужуудаас ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх;
- Аялал жуулчлалд хөрөнгө оруулах дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг хөхүүлэн дэмжиж, жуулчдад хандсан сурталчилгааг өргөтгөх;
- Аялал жуулчлалын салбарт ажиллагсадын мэргэжлийн чадвар чадавхийг олон улсын түвшинд хүргэх;

**Гарах үр дүн:** Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд аялал жуулчлалын салбарын эзлэх хувийн жин 5 хувьд хүрнэ.

### **1.6. Барилга, хот байгуулалтын хөгжил**

**Үндэслэл:** Барилгын гүйцэтгэгч 15 аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч 475 иргэн 2007 онд 4.7 тэрбум төгрөгийн барилга угсралт, засварын ажил гүйцэтгэв. Аймгийн хэмжээнд жилд дунджаар 100 гаруй хувийн сууц ашиглалтанд орж байна.

Өнөөгийн байдлаар Зуунмод сум болон сумдын төв сууринд хот байгуулалтын түвшин нэмэгдэж буй хэрэгцээнээс ихээхэн хоцорч байна.

Цаашид барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай.

### **Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Зуунмод хотыг батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу Төвийн бүсийн тулгуур төв хот болгон хөгжүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Бүсийн тулгуур төв - Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг эрчимтэй хэрэгжүүлэх;

## Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр (2008-2023 он)

- Сум бүрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг орчин үеийн хот байгуулалтын бодлоготой уялдуулан боловсруулж мөрдүүлэх;
- Ерөнхий төлөвлөгөөндөө тулгуурласан хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу инженерийн дэд бүтцийг бий болгон сайжруулах;
- Бүсийн төв сумд болон бусад томоохон суурингуудыг дулаан, цэвэр ус, ариутгах татуургын нэгдсэн системтэй болгох;
- Зуунмод хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэн засварлаж ашиглалтанд оруулах,

**Гарах үр дүн:** Аймаг, сумын төвүүдэд хүн амын тогтвор суурьшил нэмэгдэнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Орон нутгийн түүхий эд, байгалийн баялагт тулгуурласан барилгын материалын үйлдвэрүүдийг бий болгохоос гадна барилгын гүйцэтгэгч нарын чадамжийг сайжруулна.

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Орон нутгийн түүхий эд, байгалийн баялагт тулгуурлан байгальд хор хөнөөлгүй шинэ техник, технологид тулгуурласан барилгын материалын үйлдвэрүүдийг бий болгох;
- Барилгын салбарт олон давхар болон томоохон барилгын ажлыг гүйцэтгэж чадахуйц болгон чадамжийг сайжруулахын зэрэгцээ барилгын материалын сорьц лабораторуудыг бий болгох;
- Сум бүрийг барилгын засварын ажлыг гүйцэтгэх чадамжтай болгох;
- Барилгын салбарыг мэргэшилтэй боловсон хүчнээр хангах ажлыг зохион байгуулах.

**Гарах үр дүн:** Барилгын салбар эрчимтэй хөгжих үндэс суурь бүрдэнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан аймгийн орон сууцны хангамжийн түвшинг сайжруулна.

- “**40 000 айлын орон сууц**” хөтөлбөрийн хүрээнд аймгийн төвд орон сууцны хотхон, шинэ хороолол бий болгох;
- “**Орон сууц**” сан бүрдүүлж, эн түрүүнд төрийн албан хаагчид, залуу гэр бүлийг орон сууцаар хангах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Сумын иргэдийг орон сууцжуулах ;
- Амины орон сууц барьж буй иргэдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих;
- Орон сууцны хороололын хэсэгчилсэн төлөвлөлтүүдийг суурин тус бүрт хийх
- Орон сууц барих санхүүгийн эх үүсвэрүүдийг бий болгох нэмэгдүүлэх
- Гэр хорооллыг орон сууцны анхан шатны дэд бүтэц буюу цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбож иргэдийг амины орон сууцтай болгох боломжийг бүрдүүлэх замаар орон сууцны хороолол бий болгон хөгжүүлэх;

**Гарах үр дүн:** Аймаг, сумын төвүүдийн хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан орон сууцны хангамжийн түвшин 60 хувьд хүрнэ.

### **Хоёрдугаар үе шат (2017-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан иргэдийн орон сууцны хангамжийн түвшинг эрс дээшлүүлнэ.

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Аймгийн төв, сумдын бага орлоготой болон залуу гэр бүлийг орон сууцаар хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;

***Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр (2008-2023 он)***

---

- Төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны хоёр дахь шатны төсөл боловсруулан хэрэгжүүлэх;
- Амины орон сууц барьж буй иргэдийг хөнгөлөлттэй зээлээр идэвхтэй дэмжих;

**Гарах үр дүн:** Орон сууцны хангамжийн түвшинг 80 хувьд хүргэснээр хүн амын тав тухтай амьдрах ахуйн нөхцөл сайжирна.

## ХОЁР. НИЙГМИЙН ХӨГЖИЛ

### 2.1. Хүн амын өсөлт, хүний хөгжлийг хангах талаар

**Үндэслэл:** Манай аймагт 2007 оны байдлаар 88,8 мянган хүн ам оршин сууж байна. Тус аймгийн 1 км<sup>2</sup> нутагт 0,8 ногдож байгаа нь улсын дундаж (1.5)-аас 0,7 пунктээр бага байгаа ч хүн амын нягтрал харьцангуй ихтэй аймгуудын тоонд ордог. Хүн амын жилийн дундаж өсөлт 1963-1969 онд 3.2% байснаа 1989-2000 онд эрс буурч -0.1% болсон нь 1990-ээд оноос хүн амын төрөлт буурч, шилжих хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой. Төв аймагт 1990 онд 1000 хүнд ногдох төрөлт 35,84, нас баралт 6,96, цэвэр өсөлт 28,88 байсан бол 2007 онд төрөлт 8,61, нас баралт 4,37, цэвэр өсөлт 4,24 болж буурчээ. Сүүлийн нэг жилд тус аймагт 1,5 мянган хүн шилжин ирж, 3,2 мянган хүн шилжин явж, аймгийн хүн амын тоо 3,6 мянгаар өсчээ.

Манай аймагт хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлт харьцангуй доогуур түвшинд байна. 2002 онд хүний хөгжлийн индексийн улсын дундаж 0.667, манай аймгийнх 0.642 байсан бол 2006 улсын хүний хөгжлийн индекс 0,718 байхад манай аймагт 0,680 байна.

Иймд хүн амын гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулж, хүн амын өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүний хөгжлийн индексийг дээшлүүлэхэд олон асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

#### **Бүх үе шат (2008-2023 он):**

**Тэргүүлэх зорилт.** Хүн амын жилийн дундаж өсөлтийг тогтворжуулж, хүн ам өсөх нөхцлийг бүрдүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон хөгжлийн бодлого төлөвлөлтөд хүн амын хүчин зүйлсийг оновчтой тусган хэрэгжүүлдэг механизм бий болгох;
- Зуунмод хотод “Хүний хөгжлийн төв” байгуулах
- Зуунмод хот болон сумдын эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх замаар хүн ам орон нутагтаа тогтвор сууршилтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх;
- Аймгийн эдийн засгийн өсөлтийг түргэсгэн ажлын байрны хангамжийг сайжруулах замаар гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг эрс бууруулах;

**Гарах үр дүн:** Хүн амын тоо өсч, дундаж наслалт нэмэгдэнэ.

### 2.2. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах талаар

**Үндэслэл:** Аймгийн нийт хүн амын 63.69 хувь нь буюу 56347 нь хөдөлмөрийн насны хүн ам байна. Үүний 43648 ( 77.46 % ) ажиллагсад байна. Өмнөх оноос хөдөлмөрийн насны хүн ам 1.9 % (1067) , ажиллагсад 2.2 % (946 ) тус тус өссөн байна. Хөдөлмөрийн насны хүн амын 1.3 6% нь хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүд, 9.6 % ( 5321 ) нь хөдөлмөр эрхлээгүй хүн байна. Хөдөлмөрийн зах зээлийн эдийн засгийн гол үзүүлэлт болох ажиллах хүчний оролцооны түвшин 2007 оны байдлаар 78.83 хувь болж өмнөх оноос 0.4 хувиар өссөн байна. Ажил идэвхитэй хайж байгаа бүртгэлтэй ажилгүйчүүд 11.1 хувиар нэмэгдэн , хөдөлмөр эрхлээгүй хүн ам 0.68 хувиар буурч ажилгүйдлийн түвшин 1.7 хувь болсон байна.



2000 оноос Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн тоо 1.5 хувиар буурч Аймгийн ажилгүйдлийн түвшин улсын дунджаас доогуур 1.6 - 1,7 хувьтай байна.

Аймгийн нийт өрхийн 27,1 хувийг / ядуу өрх 17,4 хувийг, нэн ядуу өрх, 9,7 хувийг / ядуу, нэн ядуу өрх эзлэж байна.

Цаашид хүн амын өсөлтийг тогтворжуулж ажлын байр олноор бий болгож бодит ажилгүйдлийн түвшинг бууруулах шаардлагатай.

**Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Иргэд, ялангуяа хөдөөгийн алслагдсан иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг оновчтой тодорхойлон чанартай үйлчилгээ үзүүлж тэдний амьжиргааг дэмжинэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Өрх бүрийг үйлдвэрлэгч болгох,
- Мах сүүний чиглэлийн төрөлжсөн мал, гахай, шувуу үржүүлэх суурьшмал өрх, фермерийн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар эрчимжсэн суурьшмал аж ахуйн тоог нэмэгдүүлэх,
- Хоршоо, нөхөрлөл байгуулах, аж ахуй эрхлэх ур чадварын сургалт болон зээл санхүүгийн эх үүсвэрээр дэмжих замаар иргэдэд ажлын байраа тогтвортой хадгалах, орлогоо нэмэгдүүлэхэд нь туслах,
- Жижиг зээлийн үйлчилгээний хүрээг өргөтгөж, үйлдвэрийн тоног төхөөрөмж, үржлийн мал зэрэг үйлдвэрлэлийн нэн хэрэгцээт зүйлийг зээл, түрээс, лизингээр эзэмшүүлэх хэлбэрийг өргөн ашиглах,
- Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг албан хөдөлмөрт аажмаар шилжүүлж, тэднийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах,
- Нийгмийн даатгалд хамрагдах хүрээг нэмэгдүүлж, тэтгэврийн суурь даатгалын тогтолцоонд аймгийн хүн амыг бүрэн хамруулах;
- Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд албан бус салбарт ажиллагсдын хамралтыг нэмэгдүүлэх;
- Олон малтай ажиллах хүчний дутагдалтай өрхөд орлого багатай иргэдийг гэрээт малчны хэлбэрээр туслалцуулан ажиллуулж, шинээр фермерийн аж ахуйтай болохыг дэмжих;
- Жижиг дунд үйлдвэр, хүн амын ахуйн үйлчилгээг дэмжих, дэд бүтэц, аялал жуучлалыг хөгжүүлэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг түлхүү чиглүүлэх;
- Ажлын байр шинээр бий болгосон буюу ажилгүй иргэдэд шинээр мэргэжил олгох, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулсан ажил олгогчид дэмжлэг үзүүлэх;

**Тэргүүлэх зорилт 2.** Эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орлогыг нэмэгдүүлэх нийгэмшүүлэх арга хэмжээ авна.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Хүн амыг бэлэнчлэх сэтгэлгээнээс нь гаргаж нийгмийн эмзэг хэсгийн ядуу иргэдэд наад захын хэрэгцээгээ хангах, цаашид хөгжих дэвших бололцоо олгох чиглэлээр ажиллаж, нийгмийн халамжийн үйлчилгээг айл өрх, хувь хүний идэвхи санаачлага сонголт дээр тулгуурласан олон талт үйлчилгээ болгон өөрчилж ядуу өрх бүрт амьжиргааг дэмжих төлөвлөгөө боловруулан мөрдөх,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, ур чадварыг хөгжүүлэх хувираа болон аж ахуйн нэгж байгууллагад хөдөлмөр эрхлэхийг дэмжих,

## **Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр (2008-2023 он)**

- Хөдөө орон нутагт амьдарч байгаа эмзэг бүлгийн 30 хүртэлх насны залуу гэр бүлийг зориулалтын ажлын байраар хангах асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх,
- Иргэдэд эрчимжсэн аж ахуй, гахай, шувуу, жимс жимсгэнийн аж ахуй эрхлэх ур чадвар эзэмшүүлж, малчдыг өндөр ашиг шимтэй цөөн тооны мал маллан их орлого олох, бага газрыг тордон өндөр ургац авах, өрхийн аж ахуй эрхлэхэд сургаж, дэмжин ажиллах,

**Гарах үр дүн:** Ажилгүйдлийн түвшинг 1,2 хувь, бодит ажилгүйдлийн түвшинг 12.0 хувиас хэтрүүлэхгүй байлгаж, эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх нийгмийн хамгааллын тогтолцоо боловсронгуй болж, иргэдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж сайжирна.

### **Хоёрдугаар үе шат (2017-2023)**

**Тэргүүлэх зорилт 1.** Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг зохицуулж, ажил олгогчийн эрэлтэд түшиглэсэн сургалт зохион байгуулж ажлын байраар хангана.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, орон нутагт шуурхай үйлчилгээ үзүүлэхэд бүсийн төвүүдэд хөдөлмөрийн бирж байгуулан нэгдсэн сүлжээнд оруулан мэдээллийг шуурхай хүргэх.
- Олон малтай хүн хүчний дутагдалтай өрхөд орлого багатай иргэдийг гэрээт малчны хэлбэрээр туслалцуулан ажиллуулж, шинээр фермерийн аж ахуйтай болохыг дэмжих;

**Гарах үр дүн:** Ажлын байр нэмэгдэж ажилгүйдлийн түвшин 0,7 хувьд хүрч нийгмийн халамж үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн байна.

### **2.3. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар**

**Үндэслэл:** Хүн амын цэвэр өсөлт 2007 онд 4.24 байж, 765 эх төрж, 766 хүүхэд эсэн мэнд бойжиж байгаа нь 2006 оноос төрсөн эх 40, хүүхэд 45-аар тус тус нэмэгдсэн байна.

Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1990 оноос хойш тогтвортой буурч, 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 1990 онд 45.3 байсан бол 2007 онд 5.22 болж /улсын дундаж 17.8, аймгуудын дундаж 20.3 байгаа/ буурсан, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 онд 16.0, 2007 онд 2.6 болж Мянганы хөгжлийн зорилтот түвшинд хүрсэн. 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 1990 онд 53.8 байсан бол 2000 онд 150.0, 2002 онд 301.5 болж өссөн боловч сүүлийн 3 жилд /2005-2007/ онд эхийн эндэгдэл гараагүй байна. Аймгийн хэмжээнд 2007 онд халдварт өвчний 686 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 77.55 болж 239 тохиолдолоор буурчээ. ХДХВирус /ДОХ-ын тохиолдол бүртгэгдээгүй.

Сумын болон өрхийн эмнэлгийн дэд бүтцийг бэхжүүлэн, аймгийн нэгдсэн эмнэлгийн чадамжийг хөгжүүлэн, хүн амд ялангуяа эх хүүхэд ядуу, эмзэг бүлгийн хүмүүст хүргэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хамралт, чанарыг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

### **Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн эрүүл мэндийн хөгжлийн бодлого нь хүн амд ялангуяа хөдөө орон нутгийн алслагдсан, ядуу эмзэг бүлгийн хүмүүсийн нотолгоонд суурилагдсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлж, өвчлөл, эндэгдлийг

тууштай бууруулж, хүн амын цэвэр өсөлтийг дэмжиж, урт наслалтыг ахиулахад чиглэж, нийгмийн эрүүл мэндийн талаар аймгаас баримтлах бодлогыг хэрэгжүүлэн хүн ам эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах ая таатай нөхцлийг бүрдүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Хүн ам, ялангуяа эх, хүүхэд, ядуу болон эмзэг бүлгийн хүмүүс, малчдад хүрэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хамралт, ашиглалтыг нэмэгдүүлж, олон улсын хөл хориот өвчнөөс аймгийн хүн амыг хамгаалахад чиглэсэн лаборатори, оношлогоо, эмчилгээний явуулын багийн чадамжийг сайжруулах,
- Хувийн хэвшлийн үйл ажиллагааг өргөжүүлэн дэмжих,
- Өрхийн эмнэлгийн байр шинээр барих,
- Хорт хавдрыг эрт оношлох, эмчлэх боломжоор аймгийн нэгдсэн эмнэлгийг хангаж, шүд эмчлэх, эрхтэн тогтолцооны өвчний оношлогоо, цусны болон шээсний ерөнхий шинжилгээ, биохимийн шинжилгээ хийдэг лабораторитой болгох,
- Хөдөөгийн иргэдэд нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг жил бүр тогтмол хийх,
- Алсын зайн оношлогоог нэвтрүүлэх,
- Баянхангай, Баян, Батсүмбэр, Баянцогт, Борнуур, Баян-Өнжүүл, Бүрэн сумдын эмнэлгийг зориулалтын байртай болгох,
- Эм, биобэлдмэл, биологийн идэвхт бодис, хоол хүнсний бүтээгдэхүүний чанарын баталгааг ханган эм, биобэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх,

**Гарах үр дүн:** Аймгийн хэмжээнд хүн амын эрүүл мэндэд ээлтэй, аюулгүй орчин нөхцөл бүрдэх үндэс суурь тавигдана.

**Тэргүүлэх зорилт 2.** Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгож, эрүүл мэндийн байгууллагын материаллаг бааз, боловсон хүчний хангамжийг сайжруулна.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Эмнэлгийн боловсон хүчин, эмч, сувилагч нарын мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарч, орчин үеийн тоног төхөөрөмжийг эзэмшүүлэх, анагаах ухааны орчин үеийн ололттой танилцуулах сургалт, зөвлөгөөнийг тогтмолжуулах;
- Сумдын захиалгаар мэргэжлийн эмч бэлтгэх замаар эмнэлгийн мэргэжилтний тоог нэмэгдүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;
- Одоо байгаа эмч нарын хүрэлцээ, эрүүл мэндийн анхан шатны бүртгэл, мэдээллийн компьютержсэн сүлжээний эхлэлийг тавих;
- Төгсөлтийн дараах болон ажлын байран дахь хүний нөөц, мэргэжлийн ур чадварын тасралтгүй сургалтыг нэмэгдүүлж, эрчимжүүлэх,
- Эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтэн, ажиллагсдын цалин, шагнал, нэмэгдэл, нийгмийн баталгааг сайжруулах, урамшуулалын боловсронгуй тогтолцоог хэрэгжүүлэх,
- Санхүүгийн нөөцийг оновчтой зөв зохистой ашиглах, ялангуяа хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг бүрэн дайчлах, оновчтой ашиглах, дэмжлэг авах хөшүүрэг бий болгох;

**Гарах үр дүн:** Оношлогоо, эмчилгээ, сувилгааны чанарын түвшинг дээшлүүлэх боломж нэмэгдэн, иргэдэд хүрэх хүртээмж сайжирна.

**Хоёрдугаар шат (2017-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой тогтолцоо бүрдүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Байгаль орчныг бохирдлоос сэргийлж хог хаягдлыг зайлуулах устгах талаар аймгийн онцлогт тохирсон цогц бодлого боловсруулан хэрэгжүүлэх;
- Халдварт өвчнийг эсэргүүцэх эм тарилга, вакцины нөөцийг сайжруулах, тусламж, үйлчилгээ хүртэхэд хүндрэлтэй өрхийн хүүхдийн дархлаажуулалтанд хамрагдалтыг 98 хувиас доошгүй байлгах;
- ”Эх хүүхдэд ээлтэй аймаг” болох чиглэл баримтлан эх, нялхасын эрүүл мэндийг сайжруулах, эндэгдлийг бууруулах ялгамж заагтай бодлого хэрэгжүүлэх замаар эхийн болон нялхасын эндэгдэл, 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтыг бууруулан мянганы хөгжлийн зорилтын түвшинд хүргэх;
- Нэн ядуу, эмзэг бүлгийн хүмүүс, тахир дутуу иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх;
- Аймгийн хүн амын ундны усны эх үүсвэрийн 90-ээс доошгүй хувьд эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, рашааны эх үүсвэрийг хамгаалалт, хяналтад бүрэн авах;
- Аймгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж эмнэлгийн дагнасан болон хоршсон тусламж, яаралтай тусламж, уламжлалт эмчилгээ, нөхөн сэргээх болон сувилах эмчилгээг хөгжүүлэх бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх;

**Гарах үр дүн:** Аймгийн хэмжээнд үйлчлүүлэгчид ээлтэй, үр дүнтэй, үр ашигтай, өрсөлдөөн бүхий тогтолцоо бүрдүүлснээр эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанар дээшлэнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Аймгийн эмнэлэг эрүүл мэндийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Аймгийн ЭМГ-т эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, нэн шаардлагатай эм тарианы нөөцтэй болгох арга хэмжээ авах;
- Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох,
- Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын асуудлыг шийдвэрлэх эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлэх,
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулан эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах;
- Мэдээллийн технологийн ололт дэвшлийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх чиглэлээр тодорхой төслийг хэрэгжүүлэх;
- Хүн амын өвчлөл, нас баралтын зонхилох шалтгааныг илрүүлэх, анагаах технологийн байдалд үнэлгээ өгөх замаар хамгийн зохимжтой технологийг сорчлон нэвтрүүлэх;
- Бүх сумдын эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт хангалтыг жил бүр нэмэгдүүлэх;

**Гарах үр дүн:** Өмчийн олон хэвшилд суурилсан эмнэлгийн байгууллагуудын тогтолцоо бүрдэж, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын түвшин дээшилнэ.

**2.4. Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар.**

**Үндэслэл:** Аймгийн БТС-ын хороонд дасгалжуулагч 5, арга зүйч 5, аймгийн хэмжээнд 23 суманд орон тооны бус, 4 суманд орон тооны арга зүйч, ЕБС-дад биеийн тамирын 43 багш ажиллаж, спортын 18 холбоо, өсвөрийн шигшээ баг 2, клуб 1 үйл ажиллагаагаа явуулж байна.

Сумдын ЕБС-д биеийн тамирын багшаар хангагдсан, 14.8 хувь нь орон тооны арга зүйчтэй. Аймгийн ИТХ-аас баталсан “Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого” хэрэгжүүлсэнээр аймгийн хэмжээнд бие бялдрын хөгжил чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил судалгаанд: 2007 онд СӨБ-ын 3-6 насны 1660 буюу 38.8 хувь, ЕБС-н 7–17 насны 14912 буюу 96.8 хувь, насанд хүрэгчид /15–64 нас/ 37902 буюу 67.4 хувь нийт 54474 хүн буюу 61.5 хувийг хамрууллаа. Үүнээс СӨБ-ийн хүүхдийн 44.0 хувь, ЕБС-н сурагчдын 51.7 хувь, насанд хүрэгчдийн 42.6 хувь судалгаанд хамрагдсанаас, нийт хүүхдийн 44.2 хувь нь зохих түвшинд хүрээгүй байна.

Аймгийн хэмжээнд өсвөр үе , залуучуудын 27, насанд хүрэгчдийн 12, ахмадын 2 төрлөөр аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулан анхан шатны тэмцээнд 13586 , шигшээ тэмцээнд 3781 , нийт 17368 хүн хамрагдлаа.

2007 онд Хүүхдийн спортын 3-р их наадмыг зохион байгуулж, спортын 24 төрлөөр 3 үе шаттай зохион байгуулж, ЕБС-ийн 14058 сурагчид /91,2%/ хамрагдан, шигшээ тэмцээнд 18 төрлөөр оролцож, Олон улсын хэмжээний мастер 2, спортын мастер 3, дэд мастер 3, зэрэгтэй тамирчин 228, шүүгч 80-ыг шинээр бэлтгэн гаргасан.

Хүн эрүүл чийрэг, урт удаан амьдрах, амжилт гаргах үндэс нь биеийн дасгал хөдөлгөөн тул түүнийг хүн бүр өдөр тутмын хэрэглээ болгон хэвшүүлэх явдал гэдгийг хувь хүн, гэр бүл, хамт олонд сурталчилан ойлгуулах, нийгмийн таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, байгууллага, иргэдийн оролцоог сайжруулж өргөн түншлэлийг бий болгох замаар нийтийн биеийн тамирын ажил үйлчилгээг нийтийг хамарсан хөдөлгөөн болгон өрнүүлж, эрүүл аж төрөх ёсыг хүн амын дунд төлөвшүүлэх, спортын тодорхой төрлүүдийг хөгжүүлэх, өндөр зэрэгтэй тамирчдыг бэлтгэж гаргах асуудал чухал болж байна.

### **Нэгдүгээр үе шат: (2008-2016)**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн хүн амд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, өсвөр залуу үеийг эрүүл чийрэг бие бялдартай өсгөж хүмүүжүүлэх, иргэдийн эрүүл мэндийг бэхжүүлэх нөхцлийг бүрэлдүүлэхийн тулд биеийн тамир-чийрэгжүүлэлтийн ажлыг бүх талаар дэмжинэ.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- “Эрүүл байхын үндэс бол Хөдөлгөөн” гэсэн уриаг дэвшүүлж, хүн бүрт биеийн тамирын дасгал, хөдөлгөөний ач холбогдлыг сурталчилан ойлгуулах замаар иргэдэд бие бялдрын боловсрол, соёлыг эзэмшүүлэх,
- Спортын уралдаан тэмцээн тогтмол зохион байгуулж өндөр зэрэгтэй шилдэг тамирчдыг төрүүлж, тэднийг урамшуулах замаар амжилтыг ахиулах нөхцөл бүрдүүлэх,
- Спортын танхим, талбайн засвар үйлчилгээг тогтмолжуулж, тоног төхөөрөмж, хэрэглэл материалын хангалтыг сайжруулж, тамирчдын амжилтын түвшинг дээшлүүлэх,
- Аймгийн төвд “Спорт урлагийн цогцолбор” барьж ашиглалтанд оруулах,
- Салбарын хэмжээнд үр дүнд тулгуурласан менежментийг боловсронгуй болгож спортын тодорхой төрлүүдийг хөгжүүлэх,

**Гарах үр дүн:** Иргэдийн дунд зохиох нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн арга хэмжээг тогтмолжуулах, биеийн тамираар хичээллэх сэтгэл зүйн ухамсар, сэтгэлгээг төлөвшүүлнэ.

### **Хоёрдугаар үе шат: (2017-2023)**

**Тэргүүлэх зорилт 2.** Нийтийн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлт, хүн амын хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хүн амын насны онцлогт тохируулан зохион байгуулж бүх насны хүн амыг хамруулна.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Статистик мэдээллийн нэгдсэн сан, сүлжээтэй болгох,
- БТС-ыг хөгжүүлэх асуудлаар салбар хоорондын бодлого, үйл ажиллагааг уялдуулж төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, гэр бүл, хувь хүний оролцоог сайжруулан өргөн түншлэлийг бий болгох,
- БТС-ын ажил үйлчилгээг эрхлэх байгууллагуудын бие даасан болон өмчийн олон хэлбэрт тулгуурласан бодлогыг хэрэгжүүлэх,
- Тамирчдаа дэмжүүлэх бодлого боловсруулах

**Гарах үр дүн:** Хүн ам эрүүл мэндээ хамгаалах эрүүл саруул ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлнэ.

### **2.5. Хүн амын боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх талаар.**

**Үндэслэл:** Аймгийн боловсролыг 2007-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлж эхлээд байна.

Боловсролын салбарын хөрөнгө оруулалт жилээс жилд өсөн нэмэгдэж, сүүлийн 3 жилийн байдлаар нийт ЕБС-ийн 72.9 хувьд, дотуур байрны 71.4 хувьд, цэцэрлэгийн 55 хувьд засвар тохижуулалтын ажил хийгээд байна.

Ерөнхий боловсролын 32 сургуульд /ахлах -19 , дунд-11, хувийн-2 /, 15387 суралцагч суралцаж, 30 дотуур байранд 2137 хүүхэд сууж, 37 цэцэрлэгт 2994 хүүхэд хүмүүжиж, ЕБС-д 779, цэцэрлэгт 119 багш ажиллаж байна.

Сумдын албан бус боловсролын гэгээрэл төвүүдээр сургууль завсардсан хүүхдийн 81%-ийг, бичиг үсэг үл мэдэгч 16-аас дээш насны иргэдийн 80%-ийг бичиг үсгийн анхан ба дунд шатны сургалтанд хамруулж, Бичиг үсгийн боловсрол үндэсний хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна.

Манай аймагт суурь боловсролын хамран сургалтын бохир жин 75.1%-тай өмнөх оныхоос 1.5%-иар буурсан.

Цаашид боловсролын чанарыг зөвхөн сургуулийн сургалтын тоон үзүүлэлтээр биш хүний хөгжлийг тодорхойлох цогц чадамжийн илэрхийллээр чанаржуулах нь нэн тэргүүний зорилт болж байна.

Аймагт Монгол туургатан театр, Нийтийн номын сан, Төв музей, 26 суманд соёлын төвүүд нийт 29 соёл урлагийн байгууллага үйл ажиллагаа явуулж, тэдгээрт нийт 172 ажилтан, ажилчид ажиллаж байгаагаас мэргэжлийн боловсон хүчин 77%-ийг эзэлж байна.

Жилд дунджаар Монгол туургатан театрт 10000 гаруй үзэгчид, музейд 18000 гаруй үзэгч, номын сангаар 14500 гаруй уншигч үйлчлүүлдэг. “2007-2013 онд аймгаас баримтлах соёлын бодлого”-ыг хэрэгжүүлж байна.

Цаашид орон нутгийн онцлогт тохирсон соёл урлагийн үйлчилгээний тогтолцоог бүрдүүлж, иргэдийн оролцоог сайжруулж, нийтийн соёлын ойлголт, төлөвшилтийг дээшлүүлнэ.

**Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Боловсролын салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлж, бүх шатны сургуулиудын сургалтын чанарыг сайжруулж, аймгийн боловсролыг 2007-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Хөдөөгийн малчин өрхийн 2-6 насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаанд зуны нүүдлийн гэр цэцэрлэгийн хэлбэрийг түлхүү ашиглах,
- ЕБС-ийн дунд, ахлах ангид суралцагчдын хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх,
- ЕБС-иас завсардсан хүүхдийн албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд хамруулж, боловсрол нөхөн олгох;
- Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын бохир жин 99 хувьд, суурь боловсролын хамран сургалтын бохир жинг 91 хувьд хүргэх;
- Насанд хүрэгчдийн сурах, амьдрах хэрэгцээнд тохирсон хүртээмжтэй, чанартай АББ-ын тогтвортой үйлчилгээ бий болгох;
- Бүх нийтийн англи хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, төрийн албан хаагчдыг ажил мэргэжлээрээ шаардлагатай мэдээллийг англи хэлээр ашигладаг болгох,
- Багийн бага сургуулиудыг тохижуулж, оройн ба эчнээ сургалт явуулан, ялангуяа эмзэг бүлгийн хүүхдийн сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх;

**Гарах үр дүн:** Боловсролын тогтолцоо болон сургалтын байгууллагын хэв шинж, үйл ажиллагааг олон улсын жишигт ойртуулж, мастер төлөвлөгөөний хэрэгжилт хангагдаж “Мянганы хөгжлийн зорилт-д хүрнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх орчин, нөхцлийг бүрдүүлж, суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмшүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Аймгийн “Хүүхдийн төлөвшил хүмүүжлийг сайжруулах хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлэх;
- Боловсролын байгууллагын барилгын болон сургалтын материаллаг орчинг сайжруулах;
- “Туршилтын бааз цэцэрлэг, сургуулиудын лаборатори бүтэц”-ийг бий болгож, боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлэх;
- Боловсролын байгууллагын удирдлагын чадавхийг дээшлүүлэх;
- Багшийн мэргэжил аргагүйн ур чадварыг дээшлүүлж, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах нийгмийн баталгааг хангах;
- ЕБС-иуд цахим сургалтын лабораторитой болж, хөдөөгийн сургуулиудыг интернетэд холбох;
- Мэргэжлийн сургалт, боловсролыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, уян хатан, хүртээмжтэй, оновчтой болгох;
- Гадаад орны мэргэжлийн төрөлжсөн байгууллагууд, хандивлагчдаас боловсролын салбарын материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхийг бүх талаар дэмжих;

**Гарах үр дүн:** Эрүүл, аюулгүй орчинд сэтгэл хангалуун суралцах, ажиллах нөхцлийг бүрдүүлж, боловсролын чанартай үйлчилгээг тэгш хүртэх боломжоор хангана.

### **Тэргүүлэх зорилт 3.**

Аймгийн соёл урлагийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, чадавхийг бэхжүүлэн иргэдийн оюуны эрэлт хэрэгцээнд нийцсэн соёл урлаг, нийтийн соёл үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Соёлын байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- Аймгийн соёл урлагийг дэмжих сан байгуулна.
- Аймгийн төвд □Урлаг спортын цогцолбор□ -той болох.
- Сумдын номын сан, музей, театр, соёлын төвүүдийн байрны хангамж, материаллаг баазыг бэхжүүлэн үйлчилгээг өргөжүүлж, хүн амд мэдээлэл хүргэх төв болгон ажиллуулах арга хэмжээ авах
- Аймгийн номын санг “Номын өргөө” болгон зохион байгуулах,
- Гадаад орнууд болон харилцаат мужуудтай соёл урлагийн чиглэлээр хамтарч ажиллах
- Музейг мэдээлэл, мэдлэгийн эх сурвалж болгож сан хөмрөгийг баяжуулах
- Түүх соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, орон нутгийн аялал жуулчлалын сүлжээ, маршруттай болгох
- Соёл, урлагийн байгууллагуудыг орчин үеийн хөгжим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах

**Гарах үр дүн:** Соёл урлагийн байгууллагын үйл ажиллагаа, менежмент сайжирч хөдөөгийн хүн амд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний хүрээ өргөжиж, зах зээлийн нөхцөлд нийцсэн шинэ зохион байгуулалтанд шилжинэ.

### **Хоёрдугаар үе шат (2017-2023 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулж, сургууль төвтэй менежментийг хөгжүүлж, боловсролын нээлттэй агуулга, уян хатан арга хэлбэрийг бий болгоно.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Сургуулиудыг олон улсын боловсролын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөртэй болгох;
- Бүх шатны сургуулийн хамран сургалтыг 100 хувьд хүргэх;
- Багш мэргэжил, аргазүйн хөгжил болон цалин хөлс, урамшуулал, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх;
- Боловсролын салбарын захиргааны болон мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгох;
- Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, ЕБС, цэцэрлэгийн зарим ажил үйлчилгээг гэрээ, түрээсийн хэлбэрт шилжүүлэх;



- Мэдээлэлд тулгуурласан АББ-ын төлөвлөлт, менежментийн тогтолцоо бий болгох;
- Төрийн албан хаагчдыг англи хэлээр үйл ажиллагаа явуулах чадамжтай болгох;
- Их, дээд сургуулийн салбар сургууль байгуулах;

**Гарах үр дүн:** Оюун ухааныг эрхэмлэн дээдэлж амьдрах сэтгэлзүйн орчин бүрдэж, олон улсын стандартад нийцсэн боловсролын тогтолцоонд шилжинэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Үндэстний уламжлалт соёл урлагаа дээдлэн дэлхийн сонгодог болон орчин үеийн урлагтай хослуулан хөгжүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл.**

- Угсаатны зүй, үндэстэн ястны соёлыг хадгалж хамгаалах төвийг аймгийн төвд байгуулах
- Орон нутгийн онцлогт тохирсон соёл урлагийн үйлчилгээний тогтолцоог бий болгож, сумдын соёлын төвийг **”Хүний хөгжлийн төв”** болгон хөгжүүлэх,
- Соёл урлагийн байгууллагыг эрчимтэй хөгжүүлэх эдийн засгийн орчинг бүрдүүлж, менежментийн хувьчлалд хамруулах арга хэмжээ авах,

**Гарах үр дүн:** Соёл урлагийн байгууллагын үйл ажиллагаа, менежмент сайжирч хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.

## **ГУРАВ. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ**

### **3.1. Агаар мандлын хамгаалал**

**Үндэслэл:** Үйлдвэрлэл, үйлчилгээнд агаар бохирдуулдаггүй өндөр үр ашигтай, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, бохирдуулагч эх үүсвэрүүдийг цөөлөх, шаталт сайтай зуух, түлшийг өргөн хэрэглэх, хог хаягдлыг дахин боловсруулах, хот суурин газрыг зүлэгжүүлэх зэрэг ажлыг дэс дараатай хийж, тууштай хэвшүүлэх шаардлагатай.

#### **Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Агаар мандалын чанар, төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлтөд тавих хяналт шинжилгээ, мэдээллийн сүлжээг өргөтгөн, цэвэр агаартай давуу талаа хадгална.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Агаарын бохирдлын түвшин болон бохирдуулагч эх үүсвэрт байнгын хяналт хийж, хот суурин газруудын ус цаг уур, орчны шинжилгээний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх;
- Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого явуулах;
- Шинээр байгуулах, өргөтгөх, шинэчлэх үйлдвэрлэл, үйлчилгээ болон барилга байгууламжийн төсөлд агаар мандалд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж зөвшөөрөл олгох;
- Агаарын бохирдол үүсгэгч байгууллага, аж ахуйн нэгжийг хяналт шинжилгээнд тогтмол хамруулах;
- Гэрийн зуухны гүйцэд шатдаг технологи, утаагүй түлш нэвтрүүлэх замаар утааг багасгах;
- Авто тээврийн хэрэгслээс гарч буй хорт бодис, угаарын хийн зөвшөөрөгдөх хэмжээ, стандарт мөрдөлтөд тавих мэргэжлийн албадын хяналтын үйл ажиллагааг сайжруулж, хот суурингийн замыг цардах, ногоон байгууламжийг өргөтгөх замаар тоос дэгдэлтийг бууруулах;
- Агаар, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээний талаархи мэдээллийг сайжруулж, мэдээлэл ашиглах боломжийг нэмэгдүүлэх;
- Агаарын бохирдол, агаарын төлөв байдалд тавих хяналтыг тогтмолжуулж, нарны хэт ягаан туяанд хэмжилт хийх багаж, тоног төхөөрөмжийг аймгийн төвд суурилуулах;
- Сумын төвүүдийн Ус цаг уур, орчны шинжилгээний салбаруудын 50 хүртэл хувийг агаарын бохирдлын түвшинг хэмжих багаж, тоног төхөөрөмжөөр хангах;

**Гарах үр дүн:** Аймгийн төв болон суурин газруудад агаарын бохирдлыг хянах үр нөлөө бүхий тогтолцоо бүрдэн, ялангуяа гэр хорооллын агаарын бохирдлын хэмжээ эрс буурна.

**Тэргүүлэх зорилт 2.** Агаарын бохирдлыг бууруулах тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулж, агаар бохирдуулагчидтай хийх тэмцлийн арга хэлбэрийг боловсронгуй болгоно.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

## ***Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр (2008-2023 он)***

- Аймгийн уурын зуухнуудын тоног төхөөрөмжийг шинэчлэх;
- Зарим сумын төв, суурингийн халаалтыг цахилгаан эх үүсвэрт шилжүүлэх;
- Аймгийн төвийн айл өрхийн 70 хүртэл хувийг бүрэн шаталттай зуух, түлшээр хангах;
- Тээврийн хэрэгслэлээс агаарт гаргах төрөл бүрийн хорт хийг бууруулах зорилгоор хийн түлшээр ажилладаг тээврийн хэрэгсэл ашиглахыг 10 хувьд хүргэх;
- Гэр хороололд байршилтай ердийн галлагаатай орон сууцуудыг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг эхлүүлэх;
- Нам даралтын халаалтын зуухаар үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүдийг байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд бүрэн хамруулж, аймгийн төвийн 1 дүгээр бүсийн дулаан халаалт, хэрэглэгчдийг төвлөрсөн халаалтын сүлжээнд хамруулах;
- Шахмал түлш үйлдвэрлэхэд хувийн хэвшлийн оролцоог бүх талаар дэмжих;
- Химийн хорт болон цацраг идэвхт бодисын импорт, экспорт, тээвэрлэлт, хадгалалт, хэрэглээнд хяналт тавих тогтолцоог бий болгож мөрдөх;
- Удаан задардаг органик бохирдуулагчийн тооллого судалгааг гаргах;
- Хог хаягдал ялган боловсруулах үйлдвэрийг байгуулах;

**Гарах үр дүн:** Агаар мандлыг цэвэр ариун байлгах талаар аж ахуйн нэгж, иргэдийн үүрэг хариуцлага нэмэгдэж, бохирдлын хэмжээ буурна.

### **Хоёрдугаар үе шат (2017-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Агаарын төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлтөд тавих хяналтын хүрээг өргөтгөж, мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулна.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Эрчим хүчний системийг байгаль орчинд хал багатай тоног төхөөрөмжөөр шинэчлэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Үйлдвэрлэлийн хаягдлыг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хаягдалгүй болон дахин боловсруулах техник, технологи нэвтрүүлэх;
- Түлшний шинэ эх үүсгэвэр бий болгох, түүнийг тээвэрлэх, хадгалах, үр ашигтай хэрэглэх талаар дотоод, гадаадын туршлага, санаачилгыг идэвхтэй дэмжих;
- Агаар бохирдуулагчтай хийх тэмцлийн хүрээг өргөтгөж, энэ чиглэлийн төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх;
- Тээврийн хэрэгслэлээс агаарт гаргах төрөл бүрийн хорт хийг бууруулах зорилгоор бүсийн төв сумуудад “Техник оношлогооны төв” байгуулах;

**Гарах үр дүн:** Агаарын чанар, төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлтөд тавих хяналт сайжирч, аймгийн хэмжээнд мэдээллийн сүлжээ бий болно.

**Тэргүүлэх зорилт 2.** Аймгийн төвийн агаарын бохирдлыг эрс бууруулна.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Гэр хороололд байршилтай ердийн галлагаатай орон сууцуудыг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг үргэлжлүүлэх;
- Шахмал түлш үйлдвэрлэх хувийн хэвшлийн хүрээг улам өргөтгөх;

**Гарах үр дүн:** Агаар мандлын хамгаалалтын түвшин дэлхийн жишигт ойртоно.

### **3.2. Газрын нөөцийн ашиглалт, хамгаалал**

- **Үндэслэл:** Сүүлийн жилүүдэд малчид худаг устай өвөлжөө хаваржаа тойрон бөөгнөрсний улмаас бэлчээрийн талхагдал нэмэгдэж, авто тээврийн хэрэгслийн олон салаа зам газрын хөрсийг сүйтгэн бэлчээрийг ихээхэн хомсдуулжээ. Мөн худаг усаа эвдэж сүйтгэсний улмаас их хэмжээний бэлчээрийг ашиглаж чадахгүйд хүрчээ. Ашигт малтмал олборлолттой холбоотойгоор хөрсний эвдрэл ихсэх хандлагатай болсон. Иймд бэлчээр усжуулах замаар ашиглагдахгүй байгаа бэлчээрийн ашиглалтыг сайжруулах, газар ашиглалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэн, газар ашиглалтын менежментийг сумдын түвшинд нэвтрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

#### **Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн “Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг чанд баримтлан газрын нөөцөд экологи-эдийн засгийн үнэлгээ хийж, газрын ашиглалт, хамгаалал, мэдээллийн үйл ажиллагааг сайжруулна.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Аймгийн газар ашиглалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
  - Уул уурхай эрдэс баялгийн талаар баримтлах бодлого
  - Аялал жуулчлалын газрын талаар баримтлах бодлого
  - Бэлчээрийн газрын талаар баримтлах бодлого
  - Зуслангийн зориулалтаар эзэмшүүлэх газрын талаар баримтлах бодлого
- Газар ашиглалтын төлөв байдал, үржил шимийг дээшлүүлэх, түүнчлэн стандартын холбогдолтой мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх оновчтой тогтолцоог бий болгох;
- Газрын нөөцийн менежментийг сайжруулж, газар зохион байгуулалтын орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах;
- Уул уурхайн үйлдвэрлэл ялангуяа алтны хайгуулын болон ашиглалтын замбараагүй үйл ажиллагааны уршгаар бий болсон хохирол гажуудлыг арилгуулах, байгаль орчин, эдийн засаг, нутгийн иргэдийн эрх ашигт ноцтой хохирол учруулах явдалтай тэмцэхэд нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагын хүчийг нэгтгэн зохион байгуулах.
- Байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газар нэн ховор, ховордсон ан амьтан, ургамлын тархац болон аялал жуулчлал, эрчимжсэн МАА-н үйлдвэрлэл хөгжүүлэх бүс нутаг, ашигт малтмалын илрэл бүхий хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдоогүй газруудыг аймгийн тусгай хэрэгцээ, хамгаалалтанд авах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.
- Уул уурхайн газрын нөхөн сэргээлтэд таримал ургамал бут сөөг тарьж ургуулан, аялал жуулчлалын зориулалтаар ашиглуулах;
- Уул уурхайн хууль бус ашиглалтыг бүрэн зогсоож, байгаль орчинд халгүй дэвшитэд технологи нэвтрүүлж байгаа аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллах.
- Уул уурхайн тухайн жилийн нөхөн сэргээлтийг 70-аас доошгүй хувьд хийлгэж, нийт хөндөгдсөн талбайн нөхөн сэргээлтийг 60 %-д хүргэх.

**Гарах үр дүн:** Газар ашиглалтыг шинжлэх ухааны үндэстэй сайжруулж ашиглах нөхцөл бүрдэнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Тариалангийн болон бэлчээрийн газруудын зүй зохистой ашиглалтыг нэмэгдүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

## **Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр (2008-2023 он)**

- Мал өсгөх, үүлдэр угсааг сайжруулах зорилтуудыг бэлчээрийн даац, ус, тэжээлийн хангамж зэрэгтэй уялдуулан оновчтой төлөвлөн зохицуулж, арга механизмыг боловсронгуй болгох;
- Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах;
- Тариалангийн эргэлтээс хасагдаж байгаа талбайн хөрсний эвдрэлийг зогсоож олон наст ургамлын үр тарих, бэлчээрийн нөөцөд шилжүүлэх арга хэмжээ авах;
- Инженерийн хийцтэй уст цэгийг засварлах, шинээр гаргах ажлыг жил бүр хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж бэлчээр, усжуулалтын түвшинг дээшлүүлэх;
- Үлийн цагаан оготны тархалтыг зогсоох, хор хөнөөлийг багасгах төрөл бүрийн дэвшилтэт арга хэлбэрүүдээс орон нутагт туршиж, сонгон нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх;
- Тариалан эрхлэгчдэд газрыг өмчлүүлж, түрээслүүлэх зэргээр хөрсний эвдрэлийг бууруулах зохион байгуулалтын цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, тариалангийн талбайг тойруулж ойн зурвас тарьж ургуулах, таримал болон тэжээлийн, эмийн ургамал тариалах замаар ашиглах;

**Гарах үр дүн:** Бэлчээрийн даац хэтрэлт тариалангийн хөрсний эвдрэлийг бууруулах болон газрыг оновчтой ашиглах хандлага давамгайлна.

### **Хоёрдугаар үе шат (2017-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Газар ашиглалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Газар ашиглалтын менежментийг сумдын түвшинд нэвтрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Хөрс хамгаалах дэвшилтэт арга технологи нэвтрүүлж, байгаль орчинд сөрөг нөлөөгүй бордоог хэрэглэх;
- Худаг ус гаргах ажлыг сайжруулах замаар бэлчээрийг усжуулж, бэлчээр ашиглалтад эдийн засгийн оновчтой хөшүүргүүдийг хэрэглэх;
- Техник-технологийн оновчтой бодлого хэрэгжүүлэх замаар нэг га-гаас авах ургацын хэмжээг улсын дунджаас доошгүй хэмжээнд хүргэх;
- Тариалан эрхлэгчдэд газрыг өмчлүүлэх, түрээслүүлэх зэрэг аргаар тариалангийн хөрсний ашиглалтыг сайжруулж, эвдрэлийг зогсоох;
- Ашигт малтмал олборлолттой холбоотой хөрсний эвдрэлийг арилгах;
- Авто замын тогтсон сүлжээг бий болгон цардмал зам, сайжруулсан зам тавьж олон салаа замыг багасгах;
- Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал жуулчлал хөгжүүлэх замаар хамгаалалтын ажиллагааны бие даасан тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэх;
- Уул уурхайн тухайн жилийн нөхөн сэргээлтийг 80-аас доошгүй хувьд хийлгэж, нийт хөндөгдсөн талбайн нөхөн сэргээлтийг 70 хувьд хүргэх.

**Гарах үр дүн:** Бэлчээрийн даацын хэтрэлт, тариалангийн хөрсний эвдрэл багасч, газар ашиглалт сайжирна.

### **3.3. Усны нөөцийн ашиглалт, хамгаалал**

**Үндэслэл:** Аймгийн гадаргын ус нь Хойд мөсөн далай, Номхон далай, Төв азийн гадагш урсгалгүй ай савд хамрагддаг. Нутаг дэвсгэрийн 60 орчим хувь нь “Хойд мөсөн далайн ай сав”-д Туул болон түүний цутгал Тэрэлж, Заан, Улиастай, Сэлбэ, Баруунбаян, Галттай, Хаг, Хөлийн, Хар бух зэрэг голууд багтана. Туул гол нь Хан Хэнтийн нурууны

салбар уулс болох далайн түвшнээс дээш 2000 метр өргөгдсөн Чисаалайн сарьдаг, Шороотын давааны өврөөс гарах Намьяа, Нэргүй гэх 2 голын уулзвараас эх авна.

Нутаг дэвсгэрийн 10 гаруй хувь нь “Номхон далайн ай сав”-д багтдаг Хэрлэн голоор тэжээгдэж, 30-аад хувь нь “Төв азийн гадагш урсгалгүй ай сав”-д хамрагдах ба хур тунадас харьцангуй бага, ууршилт их учраас гол мөрний сүлжээ бага, томоохон гол мөрнүүд байхгүй ба жижиг булаг шанд, тойром бүрдүүдээс энэ мужийн гадаргын ус бүрдэнэ.

Манай аймаг нь 2680 сая шоо метр куб усны нөөцтэйгээс жилдээ 69.2 сая шоо метр кубийг ашиглаж байна.

Усны бохирдлыг багасгах, усны шинэ нөөц илрүүлэх, оновчтой ашиглах шаардлагатай. Цаашид бэлчээр усжуулах, усалгаатай газар тариалан эрхлэх, зарим төв суурингийн ундны усны чанарыг сайжруулах зэрэг олон чухал асуудлыг шийдэх хэрэгтэй.

### **Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн усны нөөцийг оновчтой ашиглаж, хамгааллыг нь сайжруулна.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Төв, суурингийн усны бохирдлыг бууруулах, цэвэршүүлэх арга хэмжээг төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх;
- Хүн амын ундны усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх бага оврын тоног төхөөрөмжийг сумдад нэвтрүүлж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны хэрэглээг нэмэгдүүлэх;
- Рашаан усны эхийг хамгаалах, тохижуулах ажлыг хэрэгжүүлэх;
- Хүний биед ашигтай, ховор элемент бүхий рашаан болон цэнгэг ус савлаж, зах зээлд нийлүүлэх;
- Бэлчээр усжуулж, экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөөгүй услалтын системүүдийг газар тариаланд ашиглах;
- Жил бүр 60-аас доошгүй уст цэгт засвар шинэчлэлтийг үргэлжлүүлэн хийж, бэлчээр усжуулалтын түвшинг 50-аас доошгүй хувьд хүргэх;
- Ус ашиглагч бүрийг тоолууртай болгох.
- Усны нөөц чанарын өөрчлөлтөнд байнгын хяналт судалгаа явуулж, усны хэмжилт хяналтын сүлжээг өргөтгөх арга хэмжээг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх;
- Хурын ус хуримтлуулж хөв, цөөрөм байгуулах асуудлыг судалж хөдөө аж ахуй, газар тариаланд ашиглах ажлыг судалж хэрэгжүүлэн усны нөөцийг хамгаалах.
- Аймгийн төвийн ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлэх;
- Томоохон гол, мөрний ай савыг хамгаалах үйл ажиллагааг сайжруулах;

**Гарах үр дүн:** Аймгийн усны нөөцийг оновчтой ашиглах, хамгаалах боломж нөхцөл бүрдэн эрүүл ахуйн шаардлага хангасан усны хэрэглээг нэмэгдүүлнэ.

### **Хоёрдугаар үе шат (2016-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Усны эх үүсвэрийг бохирдлоос хамгаалж, аймгийн хэмжээнд усны зохистой хэрэглээг хангах арга хэмжээ авна.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Усны эх үүсвэрийг бохирдох, хомсдохоос урьдчилан сэргийлэх, гол горхи, булаг шанд, рашааны эхийг тохижуулан хамгаалах, усны нөөцийн нөхөн сэргээх чадварыг сайжруулах арга хэмжээ авах;
- Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хүн амыг бүрэн хангах;
- Зарим сумын төвийн цэвэр усны шугам сүлжээг сольж, мөн гэр хорооллын айлуудын ундны усны хангамж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах;
- Гол, горхины гольдролыг эвдрэлээс хамгаалах арга хэмжээ авах;
- Уст цэг, гадаргуугийн усанд ариун цэвэр, эрүүл ахуйн бүс тогтоох, усны чанар, бохирдолтод тогтмол шинжилгээ хийх журамд шилжих;
- Гарсан бохирыг эрүүл ахуй, байгаль орчинд халгүйгээр арилгах шинэ технологи нэвтрүүлэх;
- Жил бүр 70-оос доошгүй уст цэгт засвар шинэчлэлтийг үргэлжлүүлэн хийж, бэлчээр усжуулалтын түвшинг 60-аас доошгүй хувьд хүргэх.
- Хэрлэн, Туул голын дэргэд усан сан байгуулж, газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглах, боломжийг холбогдох усны байгууллагатай хамтран судалж, төсөл хэрэгжүүлэх.

**Гарах үр дүн:** Усны нөөцийг шинэ эх үүсвэрүүдээр сэлбэн оновчтой ашиглах, хамгаалах системд шилжинэ.

### **3.4. Ойн нөөцийн ашиглалт, хамгаалал**

**Үндэслэл:** Аймгийн ойн сангийн талбай нь 1472.1 мянган га үүнээс ой модоор бүрхэгдсэн талбай нь 1236.8 мянган га буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 16.4 хувийг эзэлдэг, ойн нөөцийн хэмжээ 127.4 сая шоо метр, бүх ойн 44 хувийг онцгой болон хамгаалалтын бүс, 56 хувийг ашиглалтын бүсийн ой эзэлдэг.

Ой болон ургамлын нөөц багасахад хөнөөлт мэрэгч, шавьж багагүй нөлөөлж үүний улмаас газар нутаг ургамалгүйжиж, чийгний ууршилт нэмэгдэн цас хунгарлалт багасч цөлжилтөд нэрвэгдэх аюул нүүрлэж эхлэв. Иймд ойг хамгаалах, ашиглалтад нь тавих хяналтыг сайжруулах, нөхөн сэргээх, ухаалаг хэрэглээг төлөвшүүлэх шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

### **Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Ойн нөөцийг хамгаалах цогцолбор арга хэмжээ авч, нөхөн сэргээлтийг идэвхжүүлж, ашиглалтад нь тавих хяналтыг хүчтэй болгоно.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Аймгийн ойн нөөцийг сум, багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд шинэчлэн тогтоож, экологи-эдийн засгийн үнэлгээ хийлгэх, нөхөн сэргээх, ашиглах, хамгаалах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;
- Аймгийн ойн сангийн мэдээллийн сан, мониторингийн сүлжээ байгуулах;
- Ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх мэргэжлийн боловсон хүчин, тоног төхөөрөмжөөр хангах;
- Жил бүр нийтээр мод тарих өдрийг тогтоож, хот суурин газрыг цэцэрлэгжүүлэх, гол усны эх, тариалангийн талбай, авто замын дагуу ойн зурвас байгуулах арга хэмжээ авах;
- Ойжуулсан талбайг хамгаалах ажлыг мэргэжлийн байгууллагын удирдлага, хяналтын дор гүйцэтгэх;
- Ойг нөхөн сэргээх, түүний дагалт баялгийг бүрэн боловсруулан ашиглахад гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Хот, суурин газрын орчмыг ойжуулах, цэцэрлэгжүүлэх ажлыг төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

## ***Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр (2008-2023 он)***

- Ойг нөхөн сэргээх, төв суурин газрыг цэцэрлэгжүүлэхэд шаардлагатай тарьц, суулгац бэлтгэх мод үржүүлгийн газруудыг Лүн, Эрдэнэ, Мөнгөнморьт, Батсүмбэр, Жаргалант сумдад байгуулж байнгын ажиллагаатай болгох;
- Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, байнгын эргүүл ажиллуулах, түймэр унтраах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах;
- Хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, ойн түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх хохирлыг арилгах арга хэмжээг боловсронгуй болгож, энэ ажилд орон нутгийн иргэдийн оролцоог эрс нэмэгдүүлж, тэдэнд гэрээгээр хариуцуулан хамгаалуулах ойн сангийн хэмжээг нийт ойн сангийн 30 хувьд хүргэх.
- Мод сөөгний үр бэлтгэх, тарьц суулгац үржүүлэх ажлыг эрчимжүүлж, гол мөрний эх, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, нэрвэгдсэний улмаас ойгүй болсон нийт талбайн 10 доошгүй хувийг ойжуулах.
- Мод бэлтгэх талбайг тусгаарлах, тухайн ойн онцлогт тохирсон мод бэлтгэлийн технологийг мөрдүүлэх ажлын үр өгөөжийг дээшлүүлж, мод бэлтгэсэн талбайн байгалийн аясаараа сэргэн ургах нөхцлийг бүрдүүлж, мод бэлтгэлийн ажлын технологийн горимд тавих хяналтыг эрс сайжруулах.
- Модны өсөлт, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх зорилгоор ойн арчилгаа, цэвэрлэгээг ойн мэргэжлийн болон ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагуудад түшиглэн жилдээ 5-10 га-д ажилгүйчүүд, залуучуудыг өргөн хамруулах замаар гүйцэтгэх.
- Төв суурингийн ногоон байгууламжийн хэмжээг эрс нэмэгдүүлж, жилдээ 6000 ширхэгээс доошгүй мод тарьж, төв суурингийн ногоон байгууламжийн хэмжээг 300 га-д хүргэх.

**Гарах үр дүн:** Ойн нөөцийн хамгаалалт сайжирч, ойжуулалт, нөхөн сэргээлт ашигласан талбайн хэмжээнд хүрнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Ойг түймэр, хортон шавьж, мэрэгчдээс хамгаалах, хохирлыг арилгах, эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын цогцолбор арга хэмжээг авна.

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Ойн хортон шавьж, өвчинтэй биологийн болон байгальд халгүй бусад аргаар тэмцэх ажлыг өргөжүүлэх;
- Ойн түймрээс урьдчилан сэргийлэх, сурталчилгаа хийх, түймэр унтраах ажилд мэргэжлийн хүмүүс сургаж бэлтгэн, багаж хэрэгсэлээр хангах;
- Байгалийн нөөц ашигласны болон орчныг бохирдуулсны төлбөрийн орлогын тодорхой хувийг ойг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Ой нөхөн сэргээлтийн ажлыг эдийн засгийн хөшүүрэг хэрэглэн урамшуулж, энэ талын сургалт, сурталчилгааны ажлыг сайжруулах;

**Гарах үр дүн:** Ой хамгаалах, нөхөн сэргээх, үр дүнтэй, оновчтой систем бий болно.

### **Хоёрдугаар үе шат (2017-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Ойг хамгаалах, ашиглах эрх зүйн орчинг боловсронгуй болгож, ойн нөөцийн нөхөн сэргээлтийг сайжруулна.

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**



- Ойн экологийн тэнцвэрт байдал, нөхөн ургах нөхцөлд сөрөг нөлөө үзүүлэхгүй мод бэлтгэлийн шинэ технологийг ой, ургамалжилтын онцлогт тохируулан боловсруулж нэвтрүүлэх;
- Ой мод ашигласны төлбөрийн тодорхой хэсгийг ойг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах;
- Ойн нөхөн сэргээлтийн ажлыг эдийн засгийн хөшүүргүүдийг хэрэглэн урамшуулах;
- Хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, ойн түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх хохирлыг арилгах арга хэмжээг шинэ шатанд гаргаж, энэ ажилд орон нутгийн иргэдийн оролцоог эрс нэмэгдүүлж, тэдэнд гэрээгээр хариуцуулан хамгаалуулах ойн сангийн хэмжээг нийт ойн сангийн 50 хувьд хүргэх.
- Мод сөөгний үр бэлтгэх, тарьц суулгац үржүүлэх ажлыг эрчимжүүлж, гол мөрний эх, мод бэлтгэсэн, түймэр хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, нэрвэгдсэний улмаас ойгүй болсон нийт талбайн 30 доошгүй хувийг ойжуулах.
- Төв суурингийн ногоон байгууламжийн хэмжээг эрс нэмэгдүүлж, жилдээ 6000 ширхэгээс доошгүй мод тарьж, төв суурингийн ногоон байгууламжийн хэмжээг 500 га-д хүргэх.

**Гарах үр дүн:** Ойн нөөцийн ашиглалт, хамгаалал хөгжилтэй орнуудын түвшинд ойртож, оновчтой тогтолцоо бүрдэнэ.

### **3.5. Цөлжилт, гантай хийх тэмцэл**

**Үндэслэл:** Экологийн энэхүү эмзэг асуудлыг онцгой анхаарч, дотоод гадаадын хөрөнгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн цөлжилт, гантай хийх тэмцлийг шинэ шатанд гаргах шаардлагатай.

#### **Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Цөлжилтийг сааруулж, ургамал нөмрөгийг нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөгөөтэй хэрэгжүүлж эхлэнэ.

##### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**

- Аймгийн хэмжээнд цөлжилтийн шалтгаан, үр дагаврыг судлан тогтоож, түүнтэй тэмцэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Хөрсний элэгдлийг сааруулж, улмаар зогсоох зөв менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;
- Элсний нүүдлийг зогсоох, говийн ургамалжлыг нөхөн сэргээхэд ашиглаж болох ургамлуудыг (заг, жигд, хайлаас, харгана, бүйлс, хотир гэх мэт) туршин үзэж, тодорхой үе шаттайгаар сонгон тариалах;
- Улсын чанартай зам дагуу төвлөрсөн сумуудын орчим мал ихээр бөөгнөрч бэлчээр талхлагдахаас урьдчилан сэргийлэх газар зохион байгуулалт, ашиглалтын оновчтой бодлого явуулах;
- Сул хөрсийг тогтоох, ургамалжуулах талаар гадаад орнуудын дэвшилтэт технологийг судалж нэвтрүүлэх;

**Гарах үр дүн:** Цөлжилтийн эрчийг сааруулах бааз суурь бий болно.

#### **Хоёрдугаар үе шат (2017-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Цөлжилттэй хийх тэмцлийг эрчимжүүлнэ.

##### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Газрын элэгдэл, эвдрэл, бэлчээрийн хомсдол, хөрсний үржил шимийн доройтол, элсний нүүдэл, хуурайшилт, цөлжилтийн явцын талаар мэдээллийн нэгдсэн сан байгуулах;
- “Ногоон хэрэм” хөтөлбөртэй уялдуулан тал хээрийн бүсийн ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэн, ойн зурвас байгуулах;
- Цөлжилт газрын доройтолтой тэмцэх, нөхөн сэргээх ажилд зориулан тодорхой хэмжээний хөрөнгө төлөвлөн жил бүр төсөвт тусгаж, цөлжилтийг хянах мэдээлэл мониторингийн сүлжээ бий болгож, гангийн аюулын мэдээллийн санг аймгийн төвд байгуулах.
- Цөлжилтэй тэмцэх ажилд нутгийн иргэд болон ажилгүй иргэдийн оролцоог нэмэгдүүлж, ойн зурвас байгуулах иргэд аж ахуйн нэгжийн идэвхи санаачлагыг өрнүүлж цөлжилттэй тэмцэх ажлыг ядуурлыг бууруулах иргэдийн амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээтэй нягт уялдуулах;

**Гарах үр дүн:** Аймгийн хэмжээнд элсний нүүдлийг сааруулж, цөлжилтөөс хамгаалах оновчтой тогтолцоо бүрдэнэ.

### **3.6. Биологийн төрөл зүйлийн хамгаалал**

**Үндэслэл:** Манай аймгийн нутаг дэвсгэрт 4 баг 13 овог 23 төрөлд хамрагдах 34 зүйлийн агнуурын ач холбогдолтой хөхтөн амьтан тархсан байдаг.

Сүүлийн жилүүдэд байгалийн баялгийг зүй бусаар ашиглах явдал ихэслээ. Нэн ялангуяа дэлхийд ховордсон улаан номонд орсон амьтныг агнаж устгах явдал гарсаар байна. Иймд аймгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах, зохистой ашиглах асуудал нэн чухал байна.

#### **Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах, зохистой ашиглах эрх зүй, зохион байгуулалтын таатай орчин бүрдүүлнэ.

##### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Экологи-эдийн засгийн үнэлгээ хийх үндсэн дээр аймгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Байгаль орчны доройтол, ургамал амьтны хорогдолтой тэмцэх, нөхөн үржүүлэх, нутагшуулах ажлыг явуулахдаа үндэсний уламжлалт аргуудыг дэлхийн дэвшилтэт арга, технологитой хослуулах;
- Орон нутгийн байгаль хамгаалах төрийн бус байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх;
- Байгалийн унаган төрх, шим мандлын тэнцвэрт байдлыг хадгалах, биологийн төрөл зүйлийг хайрлан хамгаалах үзэл бодлыг хүүхэд, залуучуудад төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх;
- Сум бүрийн газар ашиглалтын төлөвлөлтөд биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг хамгаалах асуудлыг тусгаж хэвшүүлэх;
- Нэн ховор, устах аюул нүүрлэж буй амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авах;
- Биологийн төрөл зүйлийг хамгаалахад эдийн засгийн хөшүүргүүдийг хэрэглэж хэвшүүлэх;
- Аймгийн амьтан, ургамал, ой, бичил биетний мэдээллийн санг бүрдүүлэх;
- Биологийн төрөл зүйлийг хамгаалах, байгалийн аясаар нөхөн сэргээх боломж нөхцөлийг бүрдүүлж, төсөвт тодорхой хөрөнгө тусган хэрэгжүүлэх.

**Гарах үр дүн:** Аймгийн биологийн төрөл зүйлийн хэвийн өсөлтийг хангах суурь нөхцөл бүрдэнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Аймгийн биологийн зарим төрөл зүйлийг оновчтой ашиглаж, хамгаална.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Ховор ан амьтан үржиж төллөдөг, нүүдлийн болон суурин амьдардаг шувууд өндөглөдөг болон ховор ургамал бүхий газар нутгийг нөөцлөн үлдээх арга хэмжээ авах;
- Ан амьтны нөөц ашигласнаас олсон орлогыг байгаль хамгаалагч, ашиглагч этгээд, мөн нутгийн иргэдэд зохистой зөв хуваарилдаг журам хэрэгжүүлэх;

**Гарах үр дүн:** Байгалийн баялгийг экологид нөлөөлөхгүйгээр зүй зохистой ашигладаг болно.

**Хоёрдугаар үе шат (2017-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн биологийн төрөл зүйлийн ашиглалт, хамгааллыг сайжруулж, тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг өргөтгөнө.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн хөгжлийн горим, зүй тогтлыг танин мэдэх, байгалийн нөөц, баялгийг үнэлж тодорхойлох, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээрх судалгааг өргөтгөж, мэдээллийн сан бүрдүүлэх;
- Байгаль орчны доройтол, биологийн төрөл зүйлийн хомсдлыг хязгаарлан зогсоох, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх ач холбогдол бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах;
- Биологийн төрөл зүйлийн ач холбогдлын талаарх хүн амын мэдлэг, мэдээллийг сайжруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааг өргөтгөх;
- Дархан цаазат газар ба байгалийн цогцолбор газрын орчны бүсүүдэд байгаль орчинд халгүй аж төрөх хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлж эхлэх;
- Ховор, нэн ховор амьтан, ургамлыг сэргээн нутагшуулах, тарималжуулах, зориудын аргаар үржүүлэх, генийн санг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт хамруулах.

**Гарах үр дүн:** Аймгийн хэмжээнд тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ бүрэлдэн, ашиглалт хамгаалал эрс сайжрана.

**3.7. Байгалийн гамшгаас сэргийлэх, хохирлыг бууруулах талаар**

**Үндэслэл:** Зуд, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, мөндөр, хүйтэн бороо, үер, ган, хүн мал ургамал, амьтны гоц халдварт өвчин, ой хээрийн түймэр зэрэг байгалийн гэнэтийн үзэгдэл, гамшиг үе үе тохиолдож мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл болон эдийн засаг, байгаль орчинд багагүй хохирол учруулсаар байна.

Байгалийн гамшигийг судлах, урьдчилан сэргийлэх, нэгэнт тохиолдсон гамшигтай тэмцэх, учирсан хохиролыг нь багасгах чиглэлээр олон улсын байгууллагуудаас дэмжлэг туслалцаа үзүүлж, удирдлага зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээ авдаг боловч гамшигийн хохирлын хэмжээ тууштай буурахгүй байна. Цаашид аюулт үзэгдлийн урьдчилан тооцоолох цаг уурын станцууд, гамшигтай тэмцэх албадын чадавхийг дээшлүүлэх шаардлагатай болж байна.

**Нэгдүгээр үе шат (2008-2016 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хохирлыг бууруулах, шуурхай арилгах оновчтой тогтолцоог бий болгоно.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Цаг уур, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны төлөв байдал, байгалийн гамшгийн мэдээллийн төвийг байгуулан чадавхийг бэхжүүлэх;
- Аюулт үзэгдлийг урьдчилан тооцоолох, олон нийтэд мэдээлэх чиглэлээр аймаг, сумын түвшинд цаг уурын албадын чадавхийг дээшлүүлэхийн зэрэгцээ энэ чиглэлээр хашир туршлагатай малчдын зөвлөл байгуулж ажиллуулах;
- Ой, ургамлын хортон шавьжийн голомт, нүүдэл, хүн, мал амьтны гоц халдварт өвчний аюул гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх хор уршгийг арилгах, ургамал, хорио цээр, хүн, мал эмнэлгийн албаны чадавхийг дээшлүүлэх;
- Газар хөдлөлийн станцын хяналтын тоног төхөөрөмжийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж, хот, суурин бүрийг газар хөдлөлтийн хүчийг тооцон барилгажуулах;
- Мэргэжлийн хяналтын лабораторуудыг орчин үеийн техник хэрэгслэлээр бэхжүүлж, мэргэжилтнүүдэд оношлогоо шинжилгээний орчин үеийн мэдлэг эзэмшүүлэх;
- Аймгийн өвс тэжээлийн фондыг шаардлагатай сумдад байгуулах;
- Байгалийн гамшиг тохиолдсон үед хохирлыг нөхөх зорилгоор байгууллага, иргэдийг эд хөрөнгийн болон бусад, амь насны даатгалд хамруулах ажлыг сайжруулах;
- Байгаль цаг уурын гамшгийн аюулыг бууруулах, болзошгүй гамшиг ослын аюулаас урьдчилан сэргийлэх нөөц бололцоо техникийн хүчин чадлыг бий болгох;
- Байгалийн гамшгийн талаарх хүн амын мэдлэгийг байнга дээшлүүлэхэд жил бүр тусгай сургалт зохион байгуулах, эн түрүүнд шаардлагатай багаж хэрэгслээр хангах ажлыг тогтмолжуулах;
- Аймгийн Онцгой байдлын хэлтэст мэдээлэл хүлээн авах станц суурилуулж, автомат дохиолол бүхий газруудтай шууд холбогддог болгох;

**Гарах үр дүн:** Аймгийн хэмжээнд байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хохирлыг бууруулах, шуурхай арилгах чадавхи дээшилнэ.

**Хоёрдугаар үе шат (2017-2023 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Байгаль, цаг уурын онц аюултай үзэгдэлээс урьдчилан сэргийлэх оновчтой тогтолцоо бүрдүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Гамшгаас сэргийлэх, хор хөнөөлийг бууруулах, гамшигтай тэмцэх талаарх менежментийг сайжруулах;
- Байгалийн гамшиг тохиолдсон үед хохирлыг бүрэн нөхөх зорилгоор байгууллага, иргэдийг эд хөрөнгийн болон амь насны даатгалд бүрэн хамруулах;

**Гарах үр дүн:** Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хохирлыг бууруулах, шуурхай арилгах оновчтой тогтолцоо бүрдсэн байна.

## **ДӨРӨВ. НУТГИЙН УДИРДЛАГА, ЭРХ ЗҮЙН ТАЛААР**

### **4.1. Нутгийн удирдлагын талаар**

**Үндэслэл:** Аймгийн хэмжээгээр төрийн болон төсвийн 184 байгууллагад 3477 албан хаагч ажиллаж байгаа нь аймгийн нийт хүн амын 3.9 хувийг эзлэж байна.

Нийт төрийн албан хаагчдаас улс төрийн албан хаагч 5,8 хувь, төрийн захиргааных 12,2 хувь, төрийн үйлчилгээнийх 76,2 хувь, төрийн тусгай албан хаагч 5,8 хувийг тус тус эзэлдэг. Төрийн албан хаагчдын 69,5 хувь нь эмэгтэйчүүд байна.

Аймгийн хэмжээнд нийт Төрийн албан хаагчдын цалингийн сан өсч, улс төрийн албан тушаалтны цалин нэмэгдэж, төрийн албанд ажиллагчдын ажиллах нөхцөл баталгаа сайжирч байна. Цаашид иргэдэд төрийн үйлчилгээг ойр дөт болгох, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэх, төрийн байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй болж байна.

### **Нэгдүгээр үе шат(2008-2016)**

**Тэргүүлэх зорилт 1:** Нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллагын чадавхи үйл ажиллагааг сайжруулж ,төрийн үйлчилгээг хүртээмжтэй ил тод болгон, гадаад харилцаанд үр ашигтай түншлэлийг бий болгоно.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлогоо бие даан тодорхойлдог чадавхтай болгож, шийдвэрийг мэдээлэх, сурталчлах, хэрэгжүүлэх биелэлтийг зохион байгуулж гүйцэтгэлийн үр дүнг тооцох үйл ажиллагааны технологи, арга барилыг шинэчлэх,
- Бодлого шийдвэр гаргахдаа иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж тэдний санал хүсэлтийг хүлээн авч тусгах, төрийн албаны стратегийн төлөвлөлт гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг нэмэгдүүлэх
- Аймгийн төрийн байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн манлайллыг шинэ түвшинд гаргаж, орон нутгийн төрийн байгууллагыг мэргэшсэн цомхон чадварлаг ашаратаар бүрдүүлэх
- Олон хүн амтай багуудыг хуваах, цөөн хүн амтай багуудыг томсгож нэгтгэх асуудлуудыг орон нутгийн саналын үндсэн дээр шийдвэрлэх
- Сумуудыг багийн жишиг төвтэй болгож тохижуулах асуудлыг □Багийн хөгжлийг дэмжих□ үндэсний хөтөлбөрийн хүрээнд дэс дараатай шийдвэрлэж, багийн Засаг даргаар дээд боловсролтой, ажлын дадлага туршлагатай, төрийн хэргийн мэдлэгтэй хүнийг томилдог болгох
- Хамтын ажиллагааны гэрээтэй болон гэрээ байгуулах муж дүүргүүдтэй харилцан ашигтай, иж бүрэн түншлэлийн бодлогыг хэрэгжүүлэх,

**Гарах үр дүн:** Төрийн албаны бодлого, шийдвэрийг өөрийн аймгийн онцлогт тохирсон тодорхой стратегийг төлөвлөлтөөр тодорхойлж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

## **Хоёрдугаар үе шат (2017-2023)**

**Тэргүүлэх зорилт 1.** Төрийн албаны бодлого, дүн шинжилгээний болон төрийн албан хаагчийн манлайллын чадамжийг шинэ түвшинд хүргэж, байгууллагын хүний нөөцийн хөгжлийг хангах, бүх шатны төрийн байгууллагыг бэхжүүлнэ.

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй уялдуулсан урамшуулал болон хариуцлагын тогтолцоо бий болгох
- Зарим сумдыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд томсгох, бүлэг суурингийн тогтолцоо бий болгох замаар бүсчилсэн хөгжлийн зохион байгуулалтад оруулна.
- Төвлөрлийг багасгах, нутгийн удирдлагын эрх хэмжээг өргөтгөх, төрийн байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх
- Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийг үндэсний хэмжээний мэдээлэлд нийцүүлж, төрийн албыг цаасгүй технологит шилжүүлэх,
- Шууд харилцаат мужууд болон гадаад хамтын ажиллагаа тогтоосон бусад оронтой эдийн засгийн үр ашигтай харилцааг хөгжүүлэх,

**Гарах үр дүн:** Төр засгийн хууль, тогтоомжийг иргэд, олон нийтэд мэдээлж, хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, төрийн үйлчилгээг шударга шуурхай хүргэх, төрийн албаны үр чадвар, хариуцлагын тогтолцоо сайжирна.

## **4.2 Хууль эрх зүйн талаар.**

**Үндэслэл:** Хууль эрх зүйн хэрэгжүүлж буй арга хэмжээний талаархи сурталчилгаа мэдээлэлд 11000- 25000 хүн буюу нийт хүн амын 25 хувь хамрагдаж байна. Сумдын эрхзүйн мэдээллийн төв байгуулж байгаа хэдий ч сумдын иргэд аймаг хот орж хуульзүйн бүрэн хэмжээний мэдээлэл туслалцаа авах бололцоо муу, мэргэжлийн хуульчид суманд байхгүй буюу бүрэн үйлчилгээ үзүүлэх мэргэшлийн бэлтгэл ур чадвар дутмаг байна. Өнөөгийн байдлаар аймгийн хэмжээнд цагдаа олон нийтийн төв 10 баригдаж, үйл ажиллагаагаа явуулж байна. Иргэний бүртгэлийн хувьд өнөөгийн байдлаар хүн амын шилжилт хөдөлгөөний урсгал ихэссэн, иргэд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэггүй, боловсрол эрүүл мэндийн үйлчилгээ, зах зээлээ дагаж албан бусаар шилжих зэрэг байдлаас хүн амын тоо жил дараалан буурч ирсэн бөгөөд 2007 оны эцсээр 88828 хүн тоологдсон байна.

Мөн өөр аймаг хотоос тус аймагт засаг захиргааны шилжүүлэггүй 5580 хүн, манай аймгаас бусад аймаг хотод дээрхи байдлаар амьдарч байгаа 1028 хүн тоологджээ.

Цаашид аймгийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа механизмыг бүрдүүлэн цагдаа олон нийтийн төвийн тоог нэмэгдүүлж эрүүлжүүлэх, баривчлах байрны нөхцлийг сайжруулах шаардлагатай.

## **Нэгдүгээр үе шат (2008-2016)**

**Тэргүүлэх зорилт 1.** Иргэдэд эрх зүйн үйлчилгээг чанартай хүргэж, засаг захиргааны завсардалт, иргэний бичиг баримтын зөрчлийг арилгаж цэгцлэнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Сумдын түвшинд иргэдэд эрх зүйн бүх төрлийн үйлчилгээг хүргэх мэдлэг чадвар бүхий сургагч багш нарыг хуульч мэргэжилтэй болгон мэргэшүүлэх,
- Цагдаагийн албан хаагчдын сургалтын цогц хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлснээр тэдний иргэдэд үйлчлэх үйлчилгээг шинэ шатанд гаргах
- Томоохон суурин газруудыг хяналтын камертай болгон иргэд, байгууллагын аюулгүй байдлыг хангах
- Иргэний бүртгэлийг цахим хэлбэрт оруулж, бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх

**Гарах үр дүн:** Сумдын түвшинд иргэдэд эрх зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх чадвар дадалтай хуульч сургагчдыг бий болгож ажиллуулж эхэлнэ.

**Хоёрдугаар үе шат: (2017-2023)**

**Тэргүүлэх зорилт 1:** Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулан хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа-механизмыг бүрдүүлж эрх зүйн үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлж, аймгийн хэмжээнд архив, иргэний бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэн, аймгийн хүн амын тоог өсгөж, засаг захиргааны завсардлыг бүрэн арилгана.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Хууль эрх зүйн бүх төрлийн мэдээллийг байгууллагууд болон иргэдэд интернетээр дамжуулан шуурхай хүргэх тогтолцоог бий болгож, мэдээллийн сан бүхий төвүүдтэй болох,
- Төрийн архивын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэн албан хэрэг хөтлөлтийг автоматжуулах зориултын байр, цахим номын сантай болгон хадгалалт хамгаалалтын нөхцлийг сайжруулах,
- Гэмт хэрэг ихээр үйлдэгдэж буй цэгүүдэд хөдөлгөөнт эргүүлийн алба байгуулан ажиллуулснаар орон нутагт үйлдэгдэж буй танхай, мал хулгайлах зэрэг тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

**Гарах үр дүн:** Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй болохын зэрэгцээ хууль хяналтын байгууллагуудаас иргэдэд үзүүлэх бүх төрлийн эрх зүйн үйлчилгээг хүртээмжтэй болгож, архив, иргэний бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэн архивын үйлчилгээний чанарыг дээшлүүлж иргэний бүртгэлийн цахим мэдээллийн сантай болно.

### **4.3. Батлан хамгаалах, онцгой байдлын хөгжлийн талаар**

**Үндэслэл:** Төр засаг болон батлан хамгаалах чиглэлээр гарсан хууль, тогтоомж цэргийн шинэчлэлийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цугларах, шилжүүлэх байруудын томилгоот бүрэлдэхүүнийг тодотгох, дохиогоор ажиллах дадлага сургуулилт хийх, байруудын бичиг баримтыг шинэчлэн мөн орон нутгийн цэргийн отряд, суман, БХГ, БХТ-ны томилгоонуудыг тодотгож, улирал бүр дадлага сурууль хийж байна. Хавар намрын цэрэг татлагын ажлыг орон нутагт 2 үе шаттай зохион байгуулан, ЗХЖШтабаас тогтоож өгсөн хяналтын тоог жил бүр 100 хувь биелүүлж байна. Цаашид аймаг, сумдын цэргийн дайчилгааны төлөвлөгөөг шинээр боловсруулан мөрдөж зэвсэгт хүчний ангиудтай оногдуулан данслагдсан бие бүрэлдэхүүн, техникийг тодотгох ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Аймгийн онцгой байдлын хэлтэс нь Гал унтраах II зэрэглэлийн 24 дүгээр анги, Аврах отрядтойгоор нийт 59 хүний бүрэлдэхүүнтэй, 8 нэгж техниктэйгээр гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах үүргийг гүйцэтгэж байна.

Цаашид аймгийн гамшгаас хамгаалах албыг зориулалтын ДЕПО-той болгож, ой хээрийн түймэр их гарах магадлал бүхий сумдад мэрэгжлийн анги байгуулж шаардагдах хүч, хэрэгслэлээр хангах, бие бүрэлдэхүүний дадлага чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлага тавигдаж байна.

### **Бүх үе шат (2008-2023)**

**Тэргүүлэх зорилт 1.** Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Зэвсэгт хүчнийг олон талт үүрэг гүйцэтгэх чадавхи бүхий өндөр мэргэшсэн болгон хөгжүүлэхтэй уялдуулан, нутгийн захиргааны байгууллага, ард иргэдтэй харилцан ажиллах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох,
- Аюулгүй байдлын шинэ орчин нөхцөл, улсын дайчилгааны төлөвлөгөөтэй уялдсан цэргийн дайчилгааны төлөвлөгөөний олон талт хувилбаруудыг шинээр боловсруулж, мөрдүүлэх.
- Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг орон нутагт сургаж бэлтгэх зориулалтаар цэргийн ангийг түшиглэн сургалтын шинэ төв байгуулах
- Цэргийн штабын бүтэц, зохион байгуулалт, сургалт бэлтгэл, зэвсэглэл, техникийн хангалтыг үе шаттайгаар нэмэгдүүлэн хангалт хийх,
- Иргэнийг гэрээт цэргийн албанд элсүүлэх болон тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах замаар гэрээт цэргийн албыг бэхжүүлэх,

**Гарах үр дүн:** Цэргийн албан хаагчид, Зэвсэгт хүчинд гэрээгээр ажиллагсадын нийгмийн асуудал тодорхой хэмжээгээр шийдвэрлэгдэж, Монгол улсын иргэдэд эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх цэгцтэй тогтолцоо бүрдэхийн зэрэгцээ цэргийн насны залуучуудад бие бялдар, сэтгэл зүйн өндөр тэсвэр хатуужлыг эзэмшүүлэх зорилго бүхий сургалт бэлтгэлийн үйл ажиллагаа боловсронгуй болно.

**Тэргүүлэх зорилт 2.** Гамшгаас хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг боловсронгуй болгох, аймаг орон нутгийн удирдлага, гамшгаас хамгаалах штаб, алба, мэргэжлийн ангийг бодлого чиглэлээр хангаж, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, аврах, хор



уршгийг арилгах, бие бүрэлдэхүүнийг авран хамгаалах техник, хувцас багаж хэрэгслээр хангаж ажиллах нөхцөл бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж, төлөвлөлтийг орон нутгийн онцлогт тохируулан боловсронгуй болгох,
- Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн хүч хэрэгслийг бэхжүүлэх, үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх талаар үе шаттай арга хэмжээ авч гамшигтай тэмцэх үйл ажиллагаанд мэргэшүүлэх,
- Онцгой байдлын хэлтсийн бүтэц орон тоог оновчтой тодорхойлж, бие бүрэлдэхүүний мэргэжил ур чадвар, дадлага туршлагыг нэмэгдүүлэн, ажлын байрны нөхцлийг сайжруулах,
- Онцгой байдлын хэлтсийг гамшгийн холбоо, зарлан мэдээллийг орчин үеийн техник хэрэгслээр хангаснаар мэдээллийн сүлжээг сайжруулж, гамшгийн мэдээллийн сан байгуулах,
- Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг эрс сайжруулж иргэдэд сурталчилан тэдний гамшигтай тэмцэх чадварыг нэмэгдүүлэх,
- Гал унтраах ангийн зориулалтын автомашиныг шинэчлэн, зориулалтын депотой болгох,

**Гарах үр дүн:** Гамшгаас авран хамгаалах орчин үеийн техник хэрэгслэлээр хангагдаж, сумдад гамшгаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үүрэг бүхий мэргэшсэн мэргэжлийн анги бий болгосноор орон нутгийн гамшгаас хамгаалах чадвар дээшлэнэ.

## **ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТЛЭГ АРГА ХЭРЭГСЭЛ.**

Хөтөлбөрийн хэрэгжилтийг оновчтой удирдлага, зохион байгуулалтаар хангах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө санхүүгийн шаардагдах эх үүсвэрийг олж, оновчтой ашиглах, олон нийтийн оролцоог өргөтгөх нь аймгийн хөгжлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх үндсэн нөхцөл мөн.

### **5.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үндсэн чиглэл.**

- Аймгийн ИТХ, Засаг даргынүйл ажиллагааг хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр оновчтой уялдуулах;
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх жил жилийн үндсэн чиглэлд тусгах,
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар аймгийн Засаг даргын Тамгын газар, Төвийн бүсийн зөвлөл, сумдын бүсийн зөвлөл, хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоог хөхүүлэн дэмжих оновчтой арга хэрэгсэл, механизмыг бий болгох;
- Жил жилийн аймгийн төсөв, дунд хугацааны төлөвлөлтийн бусад баримт бичгүүд, төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг, нийгмийн салбар бүрээр боловсруулан хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг аймгийн хөгжлийн энэхүү хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нягт уялдуулах;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр харьцангуй богино хугацааны төрөлжсөн хөтөлбөр, төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэх;
- Дээд, дунд, доод шатны төлөвлөлтийн нэгжүүдийн үйл ажиллагааг энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр оновчтой уялдуулах;
- Хувийн хэвшил дэх төлөвлөлтийг энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэх зорилгоор эдийн засаг, эрх зүйн оновчтой механизм, хөшүүргүүдийг бий болгох;
- Статистикийн бүх түвшний үзүүлэлт, бүртгэл, мэдээллийг хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт өгөхөд тохиромжтой байх чиглэлээр боловсронгуй болгох;
- Хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтууд, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлүүдийг улс төрийн намууд сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж байх;
- Хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтуудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, давуу талуудаа бататган, сул талуудаа саармагжуулан, алдаа дутагдлаа арилгаж байх;

### **5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр.**

- Банк, санхүүгийн эх үүсвэрийг бүрэн ашиглах;
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих;
- Дотоодын хөрөнгө оруулалтыг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн ашиглах оновчтой арга механизм, хөшүүргийг бий болгох;
- Үл хөдлөх хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах оновчтой механизм, хөшүүргийг бий болгох;
- Бага хүүтэй, урт хугацаатай зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Хувийн хэвшил, аймгийн оролцоотой хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх;
- Гадаадын улс орон, олон улсын байгууллага, шууд харилцаат мужуудаас хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламж авах;

**5.3. Олон нийтийн оролцоо.**

- Шийдвэр гаргах бүх түвшинд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хэвшүүлэн төрийн үйлчилгээг сайжруулах;
- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, иргэдийг өөрсөдтэй нь холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэхэд өргөнөөр оролцуулж тэдгээрийн эрх ашгийг тууштай хамгаалах;
- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх асуудлаар бодлого боловсруулах, шийдвэр гаргахад бизнес эрхлэгчдийг өргөнөөр оролцох нөхцлийг бүрдүүлэх;
- Төрийн бус байгууллагуудын гүйцэтгэж чадах олон чиг үүргийг тэдэнд шилжүүлэх замаар хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааг өргөтгөх,
- Аймгийн боловсон хүчний цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Төрийн байгууллагын үйл ажиллагааны чиг үүргийг тодорхой болгох, дотоод зохион байгуулалт, журмыг боловсронгуй болгох;
- Төрийн бус байгууллагын олон нийттэй харилцах давуу талыг түшиглэн нийгмийн сэтгэлгээ, эрэлт хэрэгцээг судалдаг, дүгнэлт шинжилгээ хийдэг чиг үүрэг бүхий бүтэц орон тоог бий болгох;
- Хууль тогтоомж сурталчлах, эрх зүйн сургалт явуулахад шаардагдах зардлыг нутгийн захиргааны байгууллагын жил бүрийн төсөв төлөвлөгөөнд тусгаж, үр ашигтай зарцуулан сургалтын үр нөлөөг хянаж, мэдээлдэг тогтолцоог бий болгох;
- Нутгийн удирдлагын болон төсөвт байгууллагуудыг мэдээллийн нэгдсэн цахим сүлжээтэй болгож, төрийн зарим гол үйлчилгээг электрон хэлбэрээр үзүүлдэг болох;

**АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД.**

№	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	2007 оны гүйцэтгэл	Хүрэх түвшин / он /				
				2012	2016	2020	2023	
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ	тэрбум.төг	95,4	154,6	232,5	368,3	532,2	
2	Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт	хувь	26,7	10,0	12,0	12,0	14,0	
3	Хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн	тэрбум.төг	71,1	119,4	185,3	304,7	451,1	
	үүнээс	мал аж ахуйн салбарын	тэрбум.төг	55,5	97,8	156,6	264,5	398,7
		газар тариалангийн салбарын	тэрбум.төг	14,9	20,8	27,8	39,3	51,3
4	Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн дотоодын нийт бүтээгдэхүүн	тэрбум.төг	2,7	3,5	4,2	5,1	6,2	
5	Боловсруулах үйлдвэрийн дотоодын нийт бүтээгдэхүүн	тэрбум.төг	0,5	0,7	0,8	1,0	1,3	
6	Үйлчилгээ болон бусад салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн	тэрбум.төг	21,1	31,0	42,2	57,4	73,6	
7	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг жижиг дунд үйлдвэрийн тоо	ш	28	50	53	55	56	
8	Мал аж ахуй, газар тариалангийн түүхий эд боловсруулах чиглэлийн жижиг, дунд үйлдвэрийн тоо	ш	16	20	35	40	52	
9	Үйлдвэрийн аргаар боловсруулах түүхий эдийн хэмжээ	хонины ноос	тн	26,0	248,2	754,4	1268,7	1711,1
		ямааны ноолуур	тн	-	52,8	53,7	51,2	70,4
		богийн арьс шир	мян.ш	-	68,0	136,5	200,0	266,5
		бодын арьс шир	мян.ш	-	14,0	28,0	45,5	71,5
		мах	тн	-	681,0	1633,0	3183,0	4750,0
		сүү	сая. л	0,17	1,5	3,0	5,0	7,5
10	Нийт малын тоо.бүгд		мян.тол	2626,5	2757,8	2862,9	2968,0	3046,8
	үүнээс	тэмээ	мян.тол	2,1	2,7	2,9	5,9	6,1
		адуу	мян.тол	215,0	220,6	229,0	237,4	243,7
		үхэр	мян.тол	157,2	275,7	343,6	415,5	481,4
		хонь	мян.тол	1249,3	1378,9	1571,7	1626,5	1645,3
		ямаа	мян.тол	1003,0	879,9	715,7	682,7	670,3
11	Цэвэр эрлийз ба цөм сүргийн мал бүгд.		мян.тол	179,8	291,0	396,1	533,4	694,9
	үүнээс	үхэр	мян.тол	40,3	82,7	120,2	187,0	264,7
		хонь	мян.тол	86,0	137,9	204,3	244,0	296,1
		ямаа	мян.тол	53,5	70,4	71,6	102,4	134,1
12	Цэвэр эрлийз ба цөм сүргийн малын нийт малд эзлэх хувь.		хувь	6,8	10,6	13,8	18,0	22,8

**Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр (2008-2023 он)**

	үүнээс	үхэр	хувь	25,6	30,0	35,0	45,0	55,0
		хонь	хувь	6,9	10,0	13,0	15,0	18,0
		ямаа	хувь	5,3	8,0	10,0	15,0	20,0
13	Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээ.	хонины ноос	тн	1499,2	1654,7	1886,0	2114,5	2138,9
		ямааны ноолуур	тн	300,9	264,0	214,7	204,8	201,1
		богийн арьс шир	мян.ш	115,0	340,0	390,0	400,0	410,0
		бодын арьс шир	мян.ш	16,7	70,0	80,0	91,0	110,0
		мах	мян.тн	9500	13610	16330	21220	23750
		сүү	сая. л	13,5	15,0	20,0	25,0	30,0
14	Нийт эргэлтийн талбай		мян.га	112,9	118,4	118,4	118,4	118,4
15	Тариалах талбай		мян.га	36,8	68,4	68,4	68,4	68,4
	үүнээс	үр тариа	мян.га	15,3	50,0	50,0	50,0	50,0
		төмс,хүнсний ногоо	мян.га	4,2	5,1	5,6	6,0	6,5
		малын тэжээл, бусад	мян.га	17,3	13,3	12,8	12,4	11,9
16	Уринш		мян.га	25,6	50,0	50,0	50,0	50,0
17	Хураах ургац		мян.тн	53,6	118,5	130,0	139,5	150,0
	үүнээс	үр тариа	мян.тн	14,0	47,5	50,0	52,5	55,0
		төмс,хүнсний ногоо	мян.тн	36,0	51,0	55,0	60,0	65,0
		малын тэжээл	мян.тн	3,6	20,0	25,0	27,0	30,0
18	Бэлтгэх байгалийн хадлан		мян.тн	70,6	90,0	92,0	95,0	100,0
19	Мэдээлэл,харилцаа холбооны орчин үеийн сүлжээнд хамрагдалт.		хувь	77,8	100	100	100	100
20	Хүлээн авах жуулчдын тоо.		мян.хүн	7,0	10,4	11,9	13,6	15,6
21	Аймгийн хүн амын тоо		мян.хүн	88,8	98,6	104,5	110,3	119,6
22	Хүн амын жилийн дундаж өсөлт. хувь.		хувь	0,05	1,4	1,4	1,4	1,4
23	Хүн амын дундаж наслалт		тоо	67,67	67,92	68,12	68,32	68,47
24	Ажилгүйдлийн түвшин		хувь	1,5	1,4	1,2	1,1	0,7
25	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт.		хувь	66,3	80,0	99,6	99,8	100,0
26	Суурь боловсролын хамран сургалт		хувь	75,1	82,0	91,0	95,0	100,0
27	Нялхасын эндэгдэл.1000 амьд төрөлтөд.			5,20	12,09	11,60	10,08	6,38
28	Хамгаалагдсан усны эх үүсвэрийн тооны өсөлт / суурь оноос/		ш	143	160	200	250	300
29	Ойн мэргчдэд сүйтгэгдсэн талбайн бууралт/ суурь оноос/		хувь	5	30	50	60	70
30	Ашигласан модонд үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан модны эзлэх хувь. / суурь оноос/		хувь	15	10	7	5	3
31	Уул уурхайн зориулалтаар хөндөгдсөн талбайд нөхөн сэргээгдсэн талбайн эзлэх хувь / суурь оноос/		хувь	35,4	50	60	65	70

